

МОНГОЛ ХЭЛЭНД МАНЖ ХЭЛНЭЭС ОРСОН ҮГС

М.Баярсайхан*

Б.Энхсүвд**

Товч агуулга: Тус өгүүлэлд манж хэлнээс монгол хэлэнд орсон үгсийг шинжлэн тодруулахыг зорив. Үүнд, өгүүлийн эхэнд өмнөх судалгааны тоймыг гаргаж, тэдгээрт манж хэлнээс монгол хэлэнд орсон үг гэж үзсэн зарим саналын талаар өөрийн тайлбарыг бичив. Үндсэн судалгааг хийхдээ хоёр хэлний уламжлалт толь бичгүүдэд буй монгол ба манж хэлний нийтлэг үгсийг бүртгэж, тэдгээр бүртгэсэн үгсээ үе үеийн монгол хэлний дурсгал, сурвалж бичгүүдийн хэлний баримтад тохиолдож буй эсэх, тохиолдож байгаа бол ямар утгаар хэрэглэгдсэнийг нэг бүрчлэн шүүрдэн тулгаж, монгол, манж хэлний авиа зүй, бүтээвэр зүйн онцлог, бүтцээр нь задлах боломж, төрөл хэлнүүдийн баримтыг шалгуур болгон нягталсны дүнд манж хэлнээс монгол хэлэнд орсон 150 гаруй үгийг тодруулан, холбогдох тайлбар судалгааг бичив. Ингэхдээ хоёр угсаатны хэл, соёлын түүхэн харилцааг уялдуулан авч үзсэн болно.

Түлхүүр үг: монгол хэл, манж хэл, манж хэлнээс ормол үгс, хэлний харилцан нөлөөлөл

Удиртгал

Монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүн дэх харь гаралтай үгсийг олж илрүүлэх нь тухай тухайн үгсийн анхдагч утга, хэлбэр, түүний хувирлыг зөв тогтоох, үгийн сангийн баяжин хөгжсөн төлөв байдлыг таньж мэдэх, түүнчлэн хэлний харилцан нөлөөлөл, соёлын харилцааг судлах зэрэгт зайлшгүй чухаг зангилаа асуудал юм.

Ойр зэргэлдээ нутаглан, түүх, соёлын талаар харилцаатай явж ирсэн

* ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн ЭША, доктор. magsarjavbayarsaikhan@gmail.com

** МУИС-ийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор. bayarsaikhan.enkhsuvd@gmail.com

үндэстнүүд хэлний талаар ямар нэг хэмжээгээр зайлшгүй харилцан нөлөөлж ирсэн байдаг. Тэрхүү харилцан нөлөөллийг тодруулах нь зөвхөн хэлний асуудал төдий биш, бас түүх, соёлын хэлхээ холбоо, утга зохиолын харилцааны түүхэнд ч чухал ач холбогдолтой юм. Археологи, антропологи, түүх, угсаатны зүйн мэдээллээс үзэхэд түрэг, монгол, түнгүс-манж хэлний харилцан үйлчлэл олон зуун жил төдийгүй хэдэн мянган жилийн турш үргэлжилсэн байна.

Монгол, манж хоёр хэлтэн түүхийнхээ бүх л үеийн туршид зах залгаа нутаглаж, зарим нутаг оронд хутгалдан сууж ирсэн тул угсаатан хоорондын харилцан нөлөөлөл нь тэдний хэл, эд өлгийн болон оюуны соёлд тодорхой ул мөрөө үлдээжээ. Ялангуяа аль нэг үндэстэн нь улс төр, соёлын талаар товойн мандаж, харилцан биеэ эрхшээж байсан, мөн нүүдэл суурьшил зэрэг түүхэн хэрэг явдал бүхий цаг үед хэлний харилцан нөлөөлөл нь илүү мэдэгдэхүйц гарч байсан нь дамжиггүй.

Монгол ба манж жүрчин хэлний идэвхтэй харилцан нөлөөлөл нь Дай Ляо улс, Алтан улс, Юань улс, Мин, Дайчин улсын үед түлхүү холбогдоно. Хятан, жүрчин, монгол, манж хэл, бичиг тус бүс нутагт ээлж дараагаар албан ёсны төрийн хэл, бичгийн үүргийг гүйцэтгэж, улс төр нийгэм соёлын нэр томьёо, үг хэллэг бичгээр дамжин уламжилж байсны зэрэгцээ, аман яриагаар дамжин хэл хооронд харилцан нэвтэрсэн үгс ч цөөнгүй билээ.

Монгол орны хойд хэсэгт түнгүс гаралтай газар усны нэрс тохиолддог. Тэдгээрийн нэг болох Сэлэнгэ мөрний нэр нь бүр VIII зууны үед холбогдох Орхоны түрэг бичээснээ тэмдэглэгдэн үлдсэн байна. Түүнээс хожуухан цагийн угсаатан хоорондын дөт харилцааны ул мөр гэвэл, бидний үзэж байгаагаар XIII зууны үеийн Монголын хойд хэсэгт нутаглаж байсан мэргидүүд чухамдаа ихэд монголжсон түнгүс угсаатан байсан бөгөөд Хар мөрний сав нутгаас баруунш нүүдэллэн ирж суусан мохэ-гийн салаа салбар бололтой.

Дайляо улс болон Алтан улсын үед жүрчинд хятанчуудын хэл, соёлын нөлөө хүчтэй байсан бол Юань болон Мин улсын үед монголчуудын нөлөө их байжээ. Жүрчин нар нь Тэмүгэ отчигин ноён болон түүний хойчис ноёдын мэдэлд захирагдаж байв. Мингийн үед монгол ноёд язгууртнууд удаа дараа өмнөд түнгүс, жүрчин хэлтний нутагт уулгалан, алба татвар авах, ураг барилдах, зарим хэсгийг эрхшээн захирах, тийш нутаглаж, хутгалдан суух зэргээр маш нягт харилцаатай байсан бөгөөд холбогдох түүхэн баримт хангалттай их билээ. Жүрчинд монгол цол тушаал, нэр хэрэглэх явдал их байсан нь монголчуудын сүр хүч, соёлын нөлөө их байсныг харуулдаг. Жүрчин хэлэнд хятан хийгээд монгол хэлний олон үг оржээ. Жүрчин хэл бол Манжуур дахь түнгүс үндэстний хэлийг нийтлэг нэрийдсэн нэр юм. Үүнд хайши жүрчин, жанжүүгийн жүрчин болон бусад

жүрчин аялгуутан бүгд хамаарна. Жүрчин ба манж хэл хэмээх нь нэр сольсон, цаг хугацааны ялгаа байхаас бус нэг л хэл юм.

Алтай овгийн хэлний дотор үгийн сангийн хувьд илүү ойр нийтлэг үгс бүхий төрөл хэл нь монгол ба манж-түнгүсийн төрөл хэл юм. С.Старостин үгийн сангийн тооцоолон бүртгэх судалгаа хийж, Сводеш-Яхонтовын 110 үгийн жагсаалтыг макро Алтай овгийн хэлнүүдийн хүрээнд өөр зуур нь харьцуулахад монгол ба манж-түнгүсийн хэлний харилцан тохирч буй үг хамгийн их буюу 22% байна гэсэн тооцоо гаргажээ (Старостин, 1991: 98). Тэгвэл манж-түнгүсийн төрөл хэлний дотор монгол хэлний нөлөөнд хамгийн их автсан нь манж хэл бөгөөд үгийн санд нь эрт хожид нэвтэрсэн монгол үг үлэмж буй. Үүнд, Н.Поппе манж хэлний нийт үгсийн 25-30 хувиас багагүй хэсгийг монгол хэлний гаралтай үгс эзэлдэг (Poppe, 1965: 161) хэмээсэн нь нэлээн багцаатай гэж бодож байна. Түүнчлэн үгийн сангийн нэгжүүд төдийгүй, түнгүсийн бусад хэлнээс ялгарах манж хэлний үг зүйн зарим онцлогт ч гэсэн монгол хэлний нөлөө тусгал гэмээр илүү ойр төстэй зүйл байдаг.

Өнөөг хүртэлх судалгааны дүнг харахад жүрчин ба манж хэлэн дэх монгол хэлний нөлөө, монгол хэлнээс орсон үг, жүрчин ба манж нарын бичгийн соёлд монголчуудын бичгийн соёл хэрхэн нөлөөлсөн талаар нэлээд судалгаа гарчээ. Монгол судлалыг үндэслэгчдийн нэг О.М.Ковалевский монгол-орос-франц хэлний толь 3 боть бүтээлдээ монгол ба манж бичгийн хэлэнд тохирдог олон үгийг заан тэмдэглэсэн нь хожмын судлаачдад үнэт хэрэглэгдэхүүн болсоор иржээ. Тухайлбал, Г.Д.Санжеев, О.Сүхбаатар нар бүтээлдээ тэрхүү 1849 оны толийг гол хэрэглэгдэхүүнийхээ нэг болгон ашиглажээ. Манж хэлэнд орсон монгол үгийн талаар Г.Д.Санжеев, В.Котвич, Л.Лигети, Г.Дерфер, Го.Мижиддорж, Л.Мишиг, В.Розицки зэрэг эрдэмтэн судалгааны бүтээл хэвлүүлсэн байна¹. В.Розицки бээр манж хэлэнд орсон монгол үгийн талаар өмнөх эрдэмтдийн судалгааг нэгтгэн хянаж, өөрөө нэмж бүртгэснээр нийт 1381 тохироо бүхий үгийг судалгааныхаа бааз суурь болгосон байна.

Манж, монгол хоёр хэлний дундын үгийн талаар Г.Д.Санжеев, Го.Мижиддорж, Д.Баасанбат, О.Цог, Б.Түвшинтөгс болон алтай хэлний хүрээнд судалгаа хийсэн олон эрдэмтэн өөрийн судалсан сэдвийн хүрээнд,

¹ Г.Д.Санжеев “Маньчжуро-монгольские языковые параллели”, W.Kotwicz “Le Elements Mongols Dans le Mandchou” Rocznik orientalistyczny 14, 1938, pp.91-102; L.Ligeti “Le Ancient Elements Mongols Dans le Mandchou” /манж хэлэн дэх эртний монгол хэлний махбод/, АОН 10 /1960/, pp.231-248; G.Doerfer, Mongolo-Tungusica, Wiesbaden, 1985; W.Rozycki, Mongol Elements in Manchu, Indiana University, Bloomington 1994; Го.Мижиддорж, “Манж-монгол хэлний ижил язгуурт үгийн толь бичиг” 1964. ЭШӨ 2 боть; Л.Мишиг, «Манжүи яргиян кооли» хэмээх бичигт гардаг зарим монгол үгийн тухай, // МУИС. Эрдэм шинжилгээний бичиг ¹ 26 Улаанбаатар 1970, 114 т., 28-31 дүгээр талд; Л.Мишиг, О некоторых монгольских словах вошедших в маньчжурский письменный язык // ОУМЭИХ 2.

үгийн сангийн аль нэг хэсгийн хүрээнд ижил төстэй үгийн сангийн нэгжийг харьцуулан судалсан байдаг.

Монголын нууц товчоон (МНТ) судлаач Цэндийн Элдэндэй (1908-1981) “Манж хэлэн дэх «Монголын нууц товчоон»-ы үгс” хэмээх судалгааны өгүүлэл бичсэнийг 1982 онд Элдэндэйн Ардаажав нийтлүүлжээ. Зохиогч МНТ ба манж хэлэнд нийдэм байдаг 160 үгийг түүвэрлэн 1. Одоо үеийн монгол хэлэнд нэгэнтээ үгүй болсон үгс (манж үг болсон монгол үгс), 2. Одоогийн монгол хэлнээ хадгалагдсаар бүхий үгс гэж ангилан эхний хэсэгт 24 үг, удаах хэсэгт 136 үгийг тус тус товч тайлбарласан байна. Тэр бээр “Дээр өгүүлсэн «Монголын нууц товчоон»-ы 160 үгсийн дотроос 24 үгийн олонх нь монгол хэлэнд нэгэнтээ үгүй болжээ. Цөөнх нь хэдийгээр хадгалагдаж байгаа боловч үгсийн утга нь нэгэнтээ хувирчээ. ... Эдгээр үгс нь үзэнгүүт тэр үгсийн гарал (ирэл)-ыг магадалж болох бөгөөд зээллэг үгс биш бүлгээ. ... Эдгээр монгол үгс нь манж үгэнд хадгалагдсан” гэж үзсэн байна.

Харин манж хэлнээс монгол хэлэнд орсон үгийн талаар судлаачид харьцангуй бага анхаарч иржээ. Тус өгүүллээр бид монгол хэлэнд орсон манж хэлний үгсийн талаарх өмнөх илтгэлээ нэмж засварласан судалгааг толилуулж байна.

Судалгааны тойм

Монгол хэлэнд орсон манж хэлний үгийн талаар судлаачид судалгаандаа дашрам дурдах буюу тусгайлан өгүүлэл бичих, үгийн гарлын толь бичигт тусгах зэргээр судалжээ.

Г.Д.Санжеев “Маньчжуро-монгольские языковые параллели” бүтээлдээ тус хоёр хэлэнд нийтлэг 780 орчим үгийг монгол болон түнгүс төрөл хэлнүүдийн холбогдох баримтын хамт харгуулж, аль хэлнийх нь анхдагч болох, эсвэл гуравдагч хэлнээс орсон эсэхийг нягтлан судалжээ. Тэр бээр Mo. anjisu < Ma. anja, Mo. gürün < Ma. geren, Mo. qulang ‘яндан’ < Ma. hūlan, Mo. salim ‘цалин’ < Ma. saliyan, Mo. selbi ‘сэлүүр’ < Ma. selbi, Mo. sürüg ‘сүрэг’ < Ma. suruq?, Mo. tarmin /nuγusu/ < Ma. tarmin /niyehe/, Mo. masi < Ma. masila-, Mo. meyiren < Ma. meyiren, Mo. čola < Ma. čolo зэрэг 10 үгийг манж хэлнээс орсон үг гэж үзсэн байна (Санжеев, 1930).

Н.Поппе “Алтай хэлшинжлэлийн удиртгал”-даа “Манж хэл монгол хэлэнд бага нөлөө үзүүлсэн бөгөөд засаг захиргааны холбогдолтой цөөн нэр томьёо, 17-р зууны сүүл, 18-р зууны үеэр зарим цол хэргэмийн нэр нэвтрэн орсон байна” гээд *амбан*, *шүүлэнгэ*, *хаван* зэрэг үгийг жишээ болгожээ. Мөн *сэлэм* гэдэг үг түнгүс хэлнээс орсон үг байж магадгүй гээд монгол хэлэнд орсон манж түнгүс хэлний зээлдмэл үгсийг хараахан судлаагүй байгааг дурджээ (Поппе, 1965: 160).

Л.Мишиг “Монгол бичгийн хэлэнд орсон зарим нэг манж үгийн тухай” хэмээх өгүүлэлдээ: «Монгол хэлэнд орсон манж үгсийг судлан илрүүлэх явдал Монгол, Манжийн түүх, утга соёлын харилцааны чухал гэрч баримт болох төдийгүй монгол хэлний үгийн сангийн судлалд чухал хэрэгтэй зүйл юм. Түүгээр ч зогсохгүй монгол утга зохиолын эртний түүхэн дурсгалт бичиг зохиолын утга санааг зөв ухахад нэг талын чухал түлхэц болох билээ» хэмээн энэ талын судалгааны хэрэгцээ, учир холбогдлыг онцолжээ. Тэр бээр урьд судлаачид цухас дурдсан *Сэлэнгэ, сэлэм, бэйл, бэйс, хуаран* гэх мэт манж гаралтай үг буйг дурдаад, Ц.Дамдинсүрэнгийн эмхэтгэсэн “Монголын уран зохиолын дээж зуун билиг”-т орсон зохиолууд дахь манж үгийг шүүрдэн: галдаа ‘Ma. yalai da, гарын дарга’, занги ‘Ma. janggin, тушаалын нэр’, залан ‘Ma. jalan, хэргэмийн нэр’, мэйрэн ‘Ma. meiren, хэргэмийн нэр’, хуаран ‘qûwaran, цэргийн хүрээ’, хурандаа ‘qûwaran i da, хорооны дарга’, буухиа ‘Chin. bao+hiya гэсэн хоёр хятад үг нийлж бүтсэн, манжаас орж ирсэн үг байж магадгүй гэж үзсэн’, амбан ‘Ma. amban, сайд’, хаван ‘Ma. hafan, түшмэл’, сингнэх ‘Ma. simne-, шалгах’, гочиха ‘Ma. yocîqa, шадар’, түкиеэхэ ‘Ma. tukiyeke, өргөсөн’, гэбүнгтэ ‘Ma. gebungge, нэрт’, түн ‘Ma. tun, арал’, журган ‘Ma. jurgan, явдлын яам’, итэм ‘Ma. iten, тугал’, алгинч ‘Ma. algin+ci’, туршуул цэрэг’, да ‘Ma. da, дарга’, миегнэх ‘Ma. meyen+ne-, бүлэглэж’ зэрэг үг тохиолдож буйг тодруулан тайлбарлажээ (Мишиг, 1972: 39-45).

В.Розицки “Mongol Elements in Manchu” хэмээх бүтээлдээ монгол ба манж (+түнгүс) хэлний үгийн сан дахь харилцан эрт ба хожуу орсон үгс, хятад хэлнээс мөн хоёр хэлэнд орсон үг зэрэг нийдэм тохирч буй 1381 үгийг бүртгэсний дотор 33 үг буюу 2% манж хэлнээс монгол хэлэнд орсон үг байна (Розицки, 1994: 231) гэжээ. Үүнд: монгол хэлний *amban, beyile, beyise, efû, ginggin* ‘blue satin without floral design’, *gürün, qoşoi, janggi, jayirang, jalan, jabi* <tun., jaya ‘жижиг завь’, *jiyanggiyun, kijim, qalfini, qalimu, quvaran, laq-a* ‘далайн загас’, *nekelei, neke-* ‘нэхэмжлэх’ (< Ma. *lehembi*), *lo* ‘торгоны зүйл’ (chinese > ma > mo), *lolo* ‘гахайн шагай’, *luysi-, manju, mujiyan* (chinese > ma > mo), *uᠣudasun* ‘ухлаадас’ < Ma. *oho da, olum* ‘гарам’, *umda[yan], orqodai, sabq-a, selem-e, tayiquva* ‘загасны нэр’, *tamtan* ‘загасны нэр’, *turlaki* ‘турлиах’ < tun. *turaki* зэрэг үгийг манж хэлнээс монгол хэлэнд орсон үг гэж бүртгээд, эдгээр нь XVII зуунаас хойш орсон гэж үзжээ.

Ж.Төмөрцэрэн: “*ганс, авдар, авс, хундага, савх, сэлэм, дурдан, цамц* гэх мэт ахуйн чанартай үгс байхаас гадна *гүрэн, амбан, гусайда* гэх мэт төр улсын чанартай үгс ч байсан гэж тайлбарлах үндэс бий. Ялангуяа 17-р зууны үед Өвөр монгол, Ар монгол манжийн эзэнт улсын бүрэлдэхүүнд орсноос хойш улс төр зэрэг тушаалын чанартай үгс монгол хэлэнд орж ирсэн. *Журган, жинс, бэйл, бэйс, мэйрэн, цуух, хаван* гэх мэт үгс идэвхтэй хэрэглэгдэж байв” (Төмөрцэрэн, 2001: 62) гэсэн байна.

П.Аюушжав “Монгол хэлэнд орсон манж үгийн тайлбар, орчуулга” орчуулгын тухай өгүүллүүд, “Монгол хэлэнд орсон манж гаралтай үгс” зэрэг өгүүлэл нийтлүүлж, амбан, авс, бошго, бэх, бэйс, гүрэн, дажгүй, занги, залан, майхан, мэйрэн, орхоодой, сэлэм, хурандаа, хуаран, хундага, эрин, үрс, сэнж зэрэг 19 үгийг тайлбарласан (Аюушжав, 1992, 1998) байна.

Мөн В.И.Цинциус абугайн эрхэлсэн түнгүсийн хэлнүүдийн харьцуулсан толь, О.Сүхбаатар “Монгол хэлний харь үгийн толь”, Н.Балжинням “Монгол хэлний гадаад үгийн толь”, Д.Төмөртоогоо “Монгол хэлний үгийн гаралын толь” зэрэг толь бичигт манж хэлнээс монгол хэлэнд орсон үгсийг тэмдэглэсэн зүйл бий. Тухайлбал:

О.Сүхбаатар “Монгол хэлний харь үгийн толь”-доо: алгинчлах, алис < ма. *alisun*, амбаа, амбан, анван, аниа “он жил”, анхиан, атуу, атуух, бойдаа, боно, бончилго, борон /*borung*/ < *murung* ‘цоогондой, зэрлэг муур’, бошго, бутан /*butung*/ < ма. *butün* ‘нэг зүйлийн ваар сав’, буу (загас), бэйл, бэйс, гарум (урт түрийтэй гутал), гацаа, гочиха, гулдан, гүйлнэй, гүрэн, гэрди, гээгээ, дажгүй, дулан, Жидүн (уул нуруу, Хянган), залан, замар < *jami* (жимс, манжаар жамү гэж бас ув улааныг хэлнэ. Замар жимс улаан өнгөтэй гэснийг бодвол манжаас орсон үг гэж үзэх бололцоо илүү байна. хятадаар өөр үг буй), занги, зүрэм < *culmen* (жигиглэн зүссэн юм, төвөд сүрма), инанги (загас), ирүди, итэм, ич (загас), лагч (загас), лах (загас), лоолой, маатан, мамууна < *tamudun* (амьтан), марвин (нугас), мармаа (~ сугас), марман (хят. маньмань, домгийн амьтан), миегнэх, мовь < *muvi* (цэцэг), мөхрүү (загас), мэйрэн, нямдан (мод), олонц (ургамал), олхон (хуурай газар, арал), олхонууд ма. *olhonu* (овог аймгийн нэр, олхоно голын саваар нутаглаж асан), омбуу (бас омбол гэнэ), оох (загас), орим (загас), орхоодой, полоса (*pologi* ‘том дугариг сагс’), пял, сагс, салмаандар, согоц, суйх, сумаран (бялзуухай), сэлэм, тавнан, тагт, тамаа (загас), таншиг < *tangsig* (араатан), тахар, таянга (домгийн аварга загас), хаван, хайга (загас), хайчин (начин), халбин (загас), хиа, хижим (далайн амьтан), хуаран, хурандаа, хүнд, хэвэй, хэнхин (далайн мий), хэргэм, хэрмээн (цэнгэг усны загас), хэрмээ (далайн загас), хэрэм < *keri* (хижиг тахал), цуух, цуцаа < ма. *cusaga* (уналга, унаа хөсөг, унаа цуцаа), шаман (бөө), шүүлэнгэ, элбэдэн (сонин гөрөөс), элбэнх, элжин, эрин, эфү зэрэг нийт 95 үгийг манжаас ормол гэж үзжээ. Үүнд газрын нэр, овог аймгийн нэр тус бүр нэг байна.

Урианхадай Хүрэлбаатар “18 дугаар зуунаас хойш монгол хэлэнд зээлэгдэн орсон манж хэлний үг” өгүүлэлдээ «Манж хэлнээс монгол хэлэнд зээлэгдэн ороод, одоо нэгэнтээ нийт монголчуудын дунд түгээмэлжин хэрэглэгдэх болсон зарим үг нь 18 дугаар зууны үеийн монгол хэлэндээ тогтворжиж чадаагүй байсан бөгөөд нэлээд сүүлийн үе болоод монгол үг болон тогтвортой хэрэглэгдэх болсон гэдгийг түүхэн материалаас хангалттай ойлгож чадна» хэмээгээд «тэдний доторх зарим үгийг ...

тодруулахыг» (Kürelbayatur, 2014: 6) зорьжээ. Тэр бээр гүрэн < Ma. gurun ‘улс’, хомс < Ma. qomso ‘цөөн’, балай < Ma. balai ‘дэмий’, халах < Ma. hala- ‘солих’, шарах < Ma. sira- ‘залгамжлах’, үжү < Ma. uju ‘тэргүүн’, жай < Ma. jai ‘дэд’, эрин < Ma. erin ‘цаг’ зэрэг үгийг толь бичгүүдэд тулгуурлан 18 дугаар зуунаас хойш монгол хэлэнд нэвтэрсэн гэж үзжээ.

Г.Д.Санжеев, М.Н.Орловская, З.В.Шевернина нар монгол хэлний үгийн гарлын 3 боть тольдоо *amba* ‘том’ < Ma. *amba*, *amban* ‘сайд’ < Ma. *amban*, *asar* ‘асар майхан’ < Ma. *asari* ‘давхарлаг барилга’, *banji*- ‘цуглуулж бэлтгэх’ < Ma. *banji*- ‘аж төрөх’, *bayiṣaya*- ‘байцаах’ < Ma. *baiṣa*- < Chin. *pái chá*, *beyile*, *beyise*, *ṣamqay* < Ma. *ṣamhan*, *ṣese* ‘цэс’ < Ma. *ṣese* < Chin. *ṣezi*, *ṣisa* ‘час’ < Ma. *ṣise* ‘ногооны үрслэгийн талбай’ < Chin. *qizi*, *dayila*- ‘дайлж цайлахын дайлах’ < Ma. *dagila*- ‘базаах’, *duli* ‘дуль’ < Ma. *dulin* ‘дунд’, *gege* ‘гээгээ, хаад ноёдын хатагтай’ < Ma. *gege* ‘эгч, ноёдын хатагтайг хүндлэн дуудах үг’, *yaṣay*-а ‘гацаа’ < Ma. *yaṣan* ‘гацаа’, *geki*- ‘толгой дохин гэхэсхийх’ < Ma. *gehu*- ‘зөвшөөрч толгой дохих’, *gürün* ‘гүрэн’ < Ma. *gurun* ‘улс’, *jalan* ‘залан’ < Ma. *jalan*, *janggin* ‘занги’ < Ma. *janggin*, *jingkini* ‘жинхэнэ’ < Ma. *jingkini* ‘чухам’, *jurγan* ‘жургаан’ < Ma. *jurγan* ‘явдлын яам’, *kebei* ‘хэвий’ < Ma. *hebei*, *kergem* ‘хэргэм’ < Ma. *hergen* ‘үсэг, хэргэм’, *labsa*- < Ma. *labsan* ‘цас лавсан орох’, *labsi*- < Ma. *labsi*- ‘лавшин идэх’, *lantuu* ‘лантуу’ < Ma. *langtu* ‘том алх’, *layida*- ‘худаг лайдахын’ < Ma. *layihû* ‘гөрдөх’, *lolo* ‘лолой’ < Ma. *lolo* ‘гахайн шагай’, *malu* ‘малуу’ < Ma. *malu* ‘архины сав’, *manggisu* ‘доргоны өөр нэр’ < Ma. *manggisu*, *orongγu* ‘оронго гөрөөс’ < Ma. *orongγu* ‘нэг зүйл зэрлэг ямаа’, *orqudai* ‘орхоодой’ < Ma. *orho i da* ‘хүн өвсний үндэс’, *ou*-а ‘оо’ < Ma. *ufa* ‘гурил, будааны гурилаар хийсэн нүүрний оо энгэсэг’, *qabang* ‘хаван’ < Ma. *hafan* ‘түшмэл’, *qala*- ‘халах, солих’ < Ma. *hala*-‘солих, ээлжлэх’, *qalimu* ‘халим’ < Ma. *qalimu*, *qanin* ‘хайдаа’ < Ma. *qanin* ‘далайн байцай’, *qaray*-а ‘харгаа’ < Ma. *haran* ‘харгаа’, *quvaran* ‘хуаран’ < Ma. *qûwaran* ‘хороо’, *quyang* ‘хуян’ < Ma. *hûyan* ‘дал мөр хөших эмгэг’, *sisi* ‘шиш’ < Ma. *šušu* ‘шиш’, *songgin*-а ‘сонгино’ < Ma. *songgina* ‘зэрлэг сонгино’, *šošu* ‘шош’ < Ma. *šušu* ‘шиш’, *taγtu* ‘тагт’ < Ma. *taγtu* ‘асар, давхарлаг’, *tangkim* ‘танхим’ < Ma. *tanggin* ‘хүлээн авах өрөө’, *tomila*- ‘томил-’ < Ma. *tomila*-‘томил-’ зэрэг үгийг манж хэлнээс орсон үг хэмээн тэмдэглэжээ (Санжеев нар, 2015, 2016, 2018).

Академич Д.Төмөртоогоо “Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь”-доо *аги* < *age*, *амбан* < *amban*, *бэйл* < *beile*, *бэйс* < *beise*, *гацаа* < *yaṣan*, *занги* < *janggin*, *мэйрэн* < *meiren*, *омбол* < *omolo*, *орхоодой* < *orho i da*, *сарс* < *saγsu*, *сэлэм* < *seleme*, *тавнан* < *tabunang*, *тахар* < *taqûran*, *хиа* < *hiyai*, *хуанди* < *hûwangdi* < Chin. *huáng dì*, *хуаран* < *hûwaran*, *хундага* < *hûntaha*, *хурандаа* < *hûwaran i da*, *эрин* < *erin* зэрэг 19 үгийг манж хэлнээс орсон үг гэж тэмдэглэжээ.

Дээр дурдсан судалгаануудыг нэгтгэн үзвэл, монгол хэлэнд орсон манж

үгсийн багцааг гаргаж байгаа боловч, нарийвчлан нягтлаагүй, эргэлзээтэй зүйл болон нэмж тодруулах үгс цөөнгүй байна. Иймд, бид юуны өмнө зарим эргэлзээтэй үгсийн талаар авч үзээд, судалгааны үндсэн хэсэгт өөрсдийн бүртгэж тодруулсан үгсийг толилуулах болно.

Бид манж хэлний үгстэй ижил болон ойр төстэй, ормол байж болзошгүй монгол хэлний үгсийг сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн бүхий л дурсгалууд, монгол болон хятад, араб үсгээр тэмдэглэсэн монгол хэлний дурсгалууд, уламжлалт толь бичгүүд, Монголын нууц товчоон болон Цагаан түүх, Хураангуй Алтан товч, Лу.Алтан товч, Саган сэцэний Эрдэнийн товч, Шар тууж, Асрагч нэртийн түүх зэрэг XVII зууны үеийн сурвалж бичгүүдэд тохиолдож буй эсэх, тохиолдож байгаа бол ямар утгаар хэрэглэгдсэнийг нягтлан шүүрдэж үзэв. Учир нь, нэг хэлнээс нөгөө хэлэнд үг нэвтэрч шингэх нь тэдгээр хэлтэн үндэстний мандал буурал, тухай тухайн цаг үеийн нийгэм, улс төр, соёл, эдийн засгийн харилцан нөлөөлөл хэр төвшинд ямар чиглэлтэй байснаас их хамааралтай. Иймд, ормол байж болзошгүй үгсийг монгол хэлний дурсгалуудад хэдий үес тохиолдож байгааг шүүн нягтлах нь зайлшгүй чухал юм. Түүхэн тоймыг авч үзвэл, X-XII зууны үед хятан хэл жүрчин хэлэнд, XIII-аас XVII зууны эхэн хүртэлх үед монгол хэл жүрчин хэлэнд их нөлөөлж, монгол хэлний нэн олон үг манж-жүрчин хэлэнд нэвтэрч шингэсэн байдаг бол, манж хэлнээс монгол хэлэнд орсон үгс их төлөв XVII зууны дунд үеэс XIX зууны дунд хүртэлх цаг үед холбогддог билээ. Харин XVII зуунаас өмнө монгол хэлэнд орсон манж үг тун цөөн тохиолдож байна. Ормол үгсийг таньж ялгахдаа түүхэн харилцаа, түүхэн нөхцөл байдлаас гадна эдгээр хэлтний уламжлалт аж ахуй, шашин шүтлэг, угсаатны зүйн онцлог зэрэг хэлний гадаад хүчин зүйл; монгол, манж хэлний авиан зүйн үндсэн шинж хийгээд үгийн бүтцийн онцлогийн үүднээс тайлбарлах боломж, бүтээврээр задарч буй эсэх, тухайн үндэс язгуураас бүтсэн үгийн үүр, үг бүтээх чадамж, утгын хувирал, хоршоо үг бүтээхэд оролцсон байдал, холбоо үг үүсгэх чадамж, монгол ба манж-түнгүс төрөл хэл, нутгийн аялгуунууд дахь гарал нэгтэй үгсийн хэлбэр, утгын холбогдол гэх мэт олон талаас нягтлан шинжлэх нь зүйн хэрэг билээ.

Өмнөх судалгааны бүтээлүүдэд манжаас монгол хэлэнд орсон үг гэж үзсэн дараах үгсийг өөрөөр авч үзэх саналтай байна. Үүнд:

авдар, Mo. *abdar-a*. Э.В.Севортян түрэгийн хэлнүүдэд, тухайлбал: Kir., Khak. *abdīra*; Tuv. *aptara*, Kaz. *әбдіре* хэмээн том хайрцаг заасан үгс байгааг дурдаад, эдгээр үг ба монгол хэлний *abdar-a* гэсэн хэлбэрийн харьцуулалт, тархсан газар зүйн байршил зэргээс үзвэл энэ үг дундад зууны үед дурдсан түрэгийн хэлнүүдэд монгол хэлнээс орсон нь лавтай гэж үзжээ. (Севортян, 1974: 58) В.И.Цинциус нар *Evk. абдōра*, Sol. *агдар~аддар* ‘хайрцаг’ < Mo. *abdera* гэж үзсэн байна (Цинциус, 1975:

5). Мин улсад 1610 онд зохиосон Лу лун сай люэ (卢龙塞略, *lú lóng sāi lüè*) хэмээх зохиолын 20-р боть орчуулгын бүлэгт авдрыг ‘*abdura*’ гэж уншихаар галиглажээ (Manduqu, 1995: 571). Сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн дурсгалууд болон XVII зуун болон түүнээс өмнөх үеийн монгол сурвалж бичгүүдэд энэ үг тохиолдохгүй, харин үүнтэй ойролцоо утгатай *qayurᠰay* ‘хуурцаг’, *qorγu* ‘хорго’ зэрэг үг цөөнгүй тохиолдож байна. Энэ нь авдар гэдэг үгийг монголчууд хэрэглэж байгаагүй гэсэн үг биш, харин ахуйн хэрэглээний эдлэлийн нэрийн хувьд “хуурцаг”-аас утгын ялгаатай тул энэ үгийг хэрэглэх шаардлага гараагүйтэй холбоотой юм. Сэцэнцогт монгол хэлний *abdar-a*, *absa* зэрэг нь нэг гаралтай үгс (Sečenčoytu, 1988: 48) гэж үзсэнтэй санал нэг байна. Бидний бодлоор энэ үг монгол ба түнгүсийн хэлнүүдийн нийтлэг дундын үг байж болох бөгөөд эртний хэлбэр нь **habdura* байснаас монгол хэлэнд авиа ижилшин ММо. *habdara* > *abdar-a* болсон гэж үзэх нь зүйтэй санагдана. Харин манж хэлэнд авдрыг *guise* гэх ба манж монгол уламжлалт толь бичгүүдээс нягтлахад ойролцоо утгатай *horho* ‘хорго’, *hiyadan* ‘дашингат’, *hidhen* ‘хуурцаг’, *sidhen* ‘хайрцаг’, *pijan* ‘тавсаг’, *hose* ‘хос’ зэрэг юм агуулах дөрвөлжин савны нэр байхаас монгол хэлний *abdar-a* ‘авдар’-тай дүрс ойролцоо үг байхгүй байна.

авс, Мо. *absa*, Ма. *absa*. Энэ үг сонгодог монгол бичгийн хэлний өмнөх дурсгалууд, тухайлбал, XIV зууны үеийн Бурханы арван хоёр зохионгуйн орчуулгад “*beye-e yi ani absan du oroγulun /09b/*”, Тахимдуу номын орчуулгад “*könjilei selte abs-a-dur /37a1/*” хэмээн тус тус шарилын хайрцаг гэсэн утгаар тохиолдож байна (Tumurtogoo, 2006). Манж хэлний *absa* нь улиг буюу хус модны үйсэн сав, үйсэн хонгиог заана. Хоёр хэлэнд нэрлэж буй зүйл нь адилгүй боловч, модоор үйлдсэн уртавтар хөндий сав, хэрэглэлийг заадгаараа утгын бүрдүүлбэр нь нийлж байна. Түнгүсийн хэлнүүд дэх Евк. авса ~ авһа ~ апһа ~ афса ‘богц, хуурцаг’, Евп. авсь ‘богц’, Neg. авфсак ‘хайрцаг’, Oroch. абса ‘завь мэтийн хашлага’, Or. Хапсав ~ хапсау ‘цүнх, хайрцаг’, Na. апсалб- ‘завинд хашлага хийх’; Мо. **habdara* > *abdar-a* зэрэг үг гарал нэг юм. Эдгээр үгийг дундын үг гэж үзүүштэй.

атуу, атуух, Мо. *atu*, Ма. *atu* ‘эм загас’, Мо. *atuq-a* < Ма. *atuha* ‘эр загас’. Түнгүсийн төрөл хэлнүүдэд гарлын хувьд холбогдох боломжтой үг олдсонгүй. Үдэгэй эм загасыг анаса хэмээн өөрөөр хэлдэг байна. Монгол хэлэнд ‘загас хошоожин нийлж түрс орхих’ гэсэн утгат *atulᠰa*- хэмээх үг байдаг бол манж хэлний толь бичгүүдээс нэг үндэс язгууртай үг олдсонгүй. Аталцахыг манжаар “*γûdumbi*” гэдэг ажээ. Иймээс *atu*, *atuq-a* манж хэлнээс орсон үг гэж үзэх нь эргэлзээтэй.

бодох, Мо. *boda*-> *bodu*-, Ма. *bodo*- ‘бодох’. Энэ үгийг бид манж хэлнээс орсон бололтой гэж үзэж байсан боловч, Хар хотын тууриас олдсон монгол

бичгийн нэгэн дурсгалд bodaju хэлбэрээр 2 удаа тохиолдож байгаа нь эргэлзээ төрүүлсэн юм. Гэвч, манж хэлний нөлөөгөөр монгол бичгийн хэлэнд идэвхтэй хэрэглэх болсон нь эргэлзээнгүй бөгөөд баримтаас үзэхэд, XVII зууны хоёрдугаар хагасын үеэс ‘bodolγ-a’ хэмээх үүсмэл үг бичгийн хэлэнд нэвтэрч эхэлсэн байна. Түнгүс төрлийн хэлнүүдэд bodo- ‘бодох, тооцоолох’ хэмээх үг нийтлэг буй.

боно, Мо. buna, Ма. bunasu ‘жимсний нэр’. Энэ үг манж хэлээр дамжин монгол хэлэнд орсон 不納子 bùnà zǐ хэмээх хятад хэлний үг аж.

бэх, Мо. beke гэдэг үг эртдээ Хуа-и и-юй тольд тэмдэглэгдсэн байх бөгөөд манж хэлнээс орсон бус, харин монгол хэлнээс манж хэлэнд (Ма. behe) орсон, гарлын хувьд Chin. 墨 ‘me/mò’-той холбоотой үг байх магадлалтай.

гаанс, Мо. yangsa. Энэ үгийг манж хэлнээс орсон гэх нь ямар нэг үндэслэлгүй бөгөөд манж хэлэнд dambaku ʋoŋciŋ ‘үгчилбэл тамхи татуур’ гэнэ. Чухамдаа хятад хэлний 杆子 gān zi. хэмээх үгээс ирэлтэй юм.

гарум, Мо. ʋarum, Ма. ʋarun ‘гуя хүрсэн урт түрийтэй гутал’. Энэ үгийг О.Сүхбаатар манж хэлнээс орсон үг гэжээ. Бидний бодоход энэ нь ʋar+u/m гэсэн бүтэцтэй, 1. Гол гатлах газар, 2. Ус гатлахад өмсөх урт түрийтэй гутал гэсэн утгатай үг бөгөөд хоёр дахь утгаараа манж хэлэнд оржээ. Манж хэлэнд үгийн адагт m гийгүүлэгч дэвсгэрлэдэггүй учир Мо. ʋarum > Ма. ʋarun хэмээн дүрс ялимгүй хувирсан байна.

гулдан, Мо. ʋuldung, Ма. ʋuldun ‘нуман хаалга, гудам’, Англ. arch, tunnel. “Матируулан цогцолсон хотын хаалгыг гулдан хэмээмүй. Бас гүүрний доорх матируулан цогцолсон газрыг мөн гулдан хэмээмүй” (21ТТ: 470). Sol. голзй- ‘нугарах, хotoйх’, Ма. ʋıldura-/ ʋılduri- ‘доогуур малтах, хөндийлөх’, Ма. ʋılduri ‘гулдрил буюу ус урсгах суваг, хоолой’ зэрэг үг нэг гаралтай. Монгол хэлний голдирол гэдэг үгийн үндэс ʋoul ‘гол’ хэмээх үгтэй холбогдохгүй, ʋuldu ‘гулд’- үндсээс үүссэн бөгөөд ʋulduri- ‘гулдирах’ гэдэг үйлээс үүсмэл нэр ажээ. Гулдан хэмээх үгийг ормол гэж баттай хэлэхэд бэрх, хоёр хэлний аль алинд төрөл үгс нь байхаас гадна бүтцийн хувьд аль ч хэлнийх нь үүднээс задлах боломжтой дундын үгс юм.

жуух, Мо. jiyuqu. Энэ үгийг бид өмнөх илтгэлдээ Ма. ejehе ‘хааны зарлигаар үе улиран залгамжлах түшмэлд олгох үнэмлэх бичиг’ гэдгээс монгол хэлэнд орж, дуудлага сунжирсан үг агаад э эгшиг бүхий үгийг зүүн Монголын зарим аялгуунд уруулшуулж хэлэх тохиолдол байдгийн нэг илрэл гэж үзсэн билээ. Гэвч, Чин гүрнээс өмнөх үед Монголд жуух бичиг хэрэглэдэг байжээ. Батмөнх даян хааны үед хүчээ өгөгсдөд дай дарх, ал жуух сэлтийг соёрхсон ба түүнээс урьд Хубилай хаан Пагба ламд

жуух шар бичиг олгож байсан тухай Э.То-д өгүүлжээ. Мөн Хирэгүдийн Алаг дарханд ал жуух, тамга соёрхов гэж АНТ-д гардаг. Зарим судлаач энэ үгийг Chin. zháo ‘хааны зарлигийн бичгийн хүндэтгэл’ гэдэг үгээс гаралтай гэсэн байна. Энэ хятад үг Мо., Ма. joо ‘жуу’ гэж бичдэг, Мо. jiyuqu, Ма. ejehe ‘жуух’-тай утга ойролцоо хэдий ч, ялгаатай өөр үгс юм. Бидний бодлоор jiyuqu-ыг ормол бус, монгол үг гэж үзэлтэй.

зүрэм, Мо. jürm-e ‘нарийн жижиглэн зүссэн юм’. О.Сүхбаатар, О.Ковалевскийн Ма. şulmen, Tib.bsug-ma-тай холбож үзсэнийг дагажээ (Ковалевский, 1849: 2426). Энэ үгээс зүрэмдэс (jürmedesü ‘эгшээсэн махны нэг зурвас, салгасан нэг хавирга’), зүрэмлэх (jürmelekü ‘малын хавьсыг нэг нэгээр таслан зүсэх’) зэрэг үг үүсэх бөгөөд монгол хэлний зүсэх (jüsü-), жиргэх (jirgi-) зэрэг үгтэй гарал нэг юм.

лугших, Мо. luysi-, Ма. luysimbi ‘хавдсан газар идээлэн чинэж өвдөх’ (MGBB: 1-81b). Дуурайх язгуураас үүссэн лугших гэдэг үг эсрэгээр монгол хэлнээс манж хэлэнд орсон болох нь маргаангүй санагдана.

маатан, Мо.matang ‘чихэрлэг идээ’. Монгол хэлний харь үгийн тольд ирлийг нь Ма. matan хэмээн заажээ. Зүй нь Chin. 麻糖 má tang хэмээх үг монгол, манж хэлэнд дам бус, шууд орсон гэж үзэлтэй. Дашрамд өгүүлэхэд, хятад хэлний -ng төгсгөлтэй үгийг монгол бичигт ямагт их энгэлэг – ng-ээр төгсгөж бичдэг бол манж хэлэнд – ng-ээс гадна, сүүл – n-ээр төгсгөж бичсэн байдаг. Жишээ нь: g’an (鋼 gāng), šobin (燒餅 shāobīng) гэх мэт.

маш, Мо. masi, Ма. masila-‘аливаа юмыг хүчлэн үлэмжхэн олох’. Тус манж үгийг бүтцээр задалбал -la нь нэрээс үйл үг бүтээх дагавар тул үгийн үндэс нь masi байх ёстой. Гэвч манж хэлний толиуд болон түнгүсийн хэлнүүдэд masi гэсэн үг алга. Маш гэхийг манжаар umesi гэнэ. Монгол хэлний masi хэмээх үг МНТ, XIV зууны үеийн монгол хэлний дурсгалууд, ХАТ, Лу.АТ, Э.То зэрэг XVII зууны түүхэн сурвалжид цөөнгүй тохиолддог. Энэ бүхнээс үзвэл, masila- нь монгол хэлнээс манжид орсон үүсмэл үг гэж үзэх нь илүү найдвартай юм.

нэхэх, Мо. neke- ‘нэхэмжлэх’, Ма. lehe- ‘гоморхох, чамархан шаардах’. Нэхэж шаардах, хөөж гүйцэх, нөхөх зэрэг салаа утга, төрөл үг, хэлний дурсгалуудад хэрэглэгдсэн байдал зэргээс үзэхэд манж хэлнээс орсон үг гэхээс илүүтэй монгол хэлнээс манж хэлэнд орохдоо n ~ l авианы сэлгэцээр хувирсан гэж үзвэл зохино.

полоса, Мо. polosa, Ма. polori ‘бургасаар сүлжсэн томхон дүгрэг сав’. Монгол хэлний харь үгийн тольд манж хэлнээс орсон үгээр үзжээ. Чухамдаа аль аль нь Chin. 菠萝 bōluó хэмээх үгийн ормол хэлбэр юм.

савх, Мо. sabqa-a < Ма. sabqa ‘савх’, Англ. Chopstick.. Зарим хүн саваа гэдэг

үгтэй гарал нэг гэж ойлгодог ч хараахан тийм бус, харин *sabar*, *samarda-* зэрэг үгтэй гарал нэг байж болох юм. Ойрад аялгуунд савхыг бас хавчуур гэж хэлдэг байсан баримт бий. Энэ үг XVII зуун болон түүнээс өмнөх үеийн монгол бичвэрээс хараахан олдсонгүй. Гэхдээ энэ нь Чин улсын үеэс өмнө савх гэдэг үг байгаагүйн нотолгоо болж чадахгүй. Түнгүс төрөл хэлнүүдийн баримт хэрэглэгдэхүүнээс *sabqa*-тай ижил төстэй хийгээд язгуур нэг байж болох үг олдсонгүй. Иймд манж хэлнээс ормол үг гэж үзэх нь үндэслэл муутай юм.

сагс, Mo. *sayсу*, Ma. *sayсу* ‘цай, цаас зэргийг агуулах хулсаар хийсэн сэвэг’ (MGBB: 16-25a). Mo. *segsü* ‘өвсөөр мушгин хийсэн аму тариа агуулах сав’ (MGBB: 16-23b). Энд өгүүлсэн сэгсийг манжаар *uri* хэмээжээ. Харин таван хэлний тольд Ma. *segsu*-г монголоор лүү хөнөг (*lüü könüg*) гэжээ. Одоогоор сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд болон Ижил мөрний торгууд (халимаг) аялгууны баримтад энэ үг олдсонгүй. Ордос аялгуунд сэгс (*segsü*) гэж нуруундаа шороо зөөх жижиг сагсыг хэлдэг аж (Mostaert, 1968: 570). Сагс, сэгс зэрэг үг нь өвс, хулс зэргийг сүлжиж хийсэн савны сэгсгэр сийрэг шинжийг дүрсэлж хэлсэн монгол үг гэмээр. Сэцэнцогт сагсайх, сагс зэрэг гарал нэг байж мэднэ гэж таамаглажээ (Sečenčoytu, 1988: 1466). Манжаар утгаа *šori*, *uri* гэж хэлдэг атал монгол хэлний *sayсу*, *segsü* манж хэлэнд орж, бага сага утгын ялгаатай хэрэглэх болсон байж болох юм.

сүрэг, Mo. *sürüg*, Ma. *suruq*. Манж хэлний толь бичгүүдэд В.Розицкийн бичсэнчлэн ийм үг олдсонгүй. Манжаар сүрэг гэхийг *feniyeu* гэнэ. Монгол хэлний сүрэг гэдэг үгийг манж хэлнээс орсон гэх нь илэрхий ташаарсан хэрэг юм.

сэлбэ, Mo. *selbi* ‘сэлүүр’, Ma. *selbi*. Энэ үгтэй үндэс нэг Mo. *seli-*, *seligür*, *selbi-*, *selbigür*, Ma. *selbimbi* ‘сэлэх, усчлах, умбах’ зэрэг үг бий. Харин түнгүсийн бусад хэлэнд холбогдох үг олдсонгүй. Тус нэр үгийн утгыг тольд “Хоёр этгээдийг халбагар хийж, барих газрыг моголцог болгож, хоёр гараар солгой баруун этгээдийг сэлбин явахыг нь сэлбүүр (Ma. *selbi*) хэмээмүй” (MGBB: 17-53b) хэмээн тайлбарласан бол үүнтэй ойролцоо утгатай урт халбагар, богино иштэй, хоёр гартаа тус тус нэжгээдийг барьж татах хэрэглүүрийг Ma. *melbi*, Mo. татуур гэх бөгөөд татуураар татахыг Ma. *melbimbi* гэдэг аж. Лу.АТ-д загас сэлэхийг “*jīyasun selbikü*” гэж нэг удаа тохиолдож байна. Одоогоор *selbi*, *selbi*-ийг манж хэлнээс монгол хэлэнд орсон, эсвэл монгол хэлнээс манжид орсон гэж баттай хэлэх үндэслэл үгүй байна.

тавнан, Mo. *tabunang* < Mo. *tabun*+Chin. 王wáng. Умард Юанийн үед монгол хятад үг нийлж бүтсэн тавнан хэмээх үг хожим Чингийн үед хаан, ван, бэйл, бэйс, гүнгийн хүргэнийг заах үг болжээ. Бас эфү тавнан гэж хоршин

хэлдэг. Манжаар хүргэнийг *hojihon*, хүргэн ахыг *efu* гэх бөгөөд Чингийн үед хааны хүргэнийг мөн *efu* гэж байв.

ухдас, *uyudasun* ~ *oyodasun*. В.Розицки бээр Г.Дөрфериин бүтээлдээ дурдсан *oyodasun* ‘Zwickel unter dem arm’ (Doerfer, 1985: 25) хэмээх үгийг Ма. *oho da* ‘суганы язгуур буюу суга тушаа ханцуйны доод уг этгээд’ гэдэг үгийн монгол хэлэнд орсон хэлбэр гэж үзсэн байна (Rozycki, 1994: 166). Гэвч монгол хэл аялгуудын баримтаас ийм үг олдохгүй байгаа бөгөөд одоогийн халхын аялгуунаа ухлаадас гэж хэлдэг үгтэй ойролцоо утгат *uqudasu* гэдэг үг бидний олж үзээгүй аль нэгэн баримтад байсан байж магадгүй. Юу боловч, манж хэлний *oho da* монгол хэлэнд орж, дуудлага сунжирсан гэж үзэх боломжгүй юм.

ундаа, *Mo. umda[yan]*, Ма. *omimbi* ‘уух’. *Mo. usun*, *uu-yu-*, Ма. *omin* ‘өлөн’, *omihon* ‘өлсгөлөн’, *omingya* ‘унд’ зэрэг үг гарал нэг. Аль аль нь уугуул дундын үг гэж үзэж байна.

үрс, *Mo. üg-e*, Ма. *use*. Энэ үг өвөг алтай хэлний **rüre* хэлбэрээс микро алтай овгийн хэлнүүдэд салбарлан хувьсаж, уламжилсан дундын уугуул үг болох тухай В.И.Цинциус судалгааны өгүүлэлдээ дэлгэрэнгүй судлан гаргасан болно (Цинциус, 1972: 52-60).

хиа, *Mo. kiy-a*, Ма. *hiya*. Зарим тольд энэ үгийг манж хэлнээс орсон үг гэж үзжээ. *Uig. hiya*, *Tib. kiya*. Ковалевскийн тольд *Chin. hia* хэмээн харгуулан бичжээ. Энэ үгийн гарал хараахан тодорхойгүй ч, багцаалбал XIV зууны үед хятад хэлнээс орсон үг байх магадлал илүү. Харин хожим монгол хэлнээс манж хэлэнд орсон нь эргэлзээнгүй санагдана.

хомс, *Mo. qomsa* < Ма. *qomso* ‘цөөн’, Англ. *few, little, a little bit*. МНТ-ны §232-д “*undān ide’en-i qor qomsa bolu’asu daruqalaqdaqsat kehte’ül-ese eriya ke’eba*” (Rachewilts, 1972: 134) Ундаан идээнийг хор хомс болбоос даргалагдагсад хэвтүүлээс эрье” хэмээв. (Чоймаа, 2011: 194) МНТ-д гарч буй энэ “хор хомс” гэдэг хоршоо үгийн *qor* болон *qorqu* (цөөрөх), *qomsa*, *qomur* ~ *qobur* зэрэг нь нэг язгуур гаралтай монгол үг. Харин манж хэлэнд хомс, ховрыг *osohon*, *simaciqa* гэдэг. Иймээс монгол хэлний *qomsa* гэдэг үг манж хэлэнд орж цөөн гэсэн утга илтгэх болсон нь тодорхой байна. Хэлбэрийн хувьд ч гэсэн *qomsa* нь *qomso*-г бодвол эртний хэлбэр гэдэг нь илэрхий.

цамц. Эдгээрээс **цамц**-тай дүйх үг манж-түнгүсийн хэлнүүдэд ма. *šamci* ‘эмэгтэйчүүдийн дээлийн дотуур өмсөх цэгдэгээс уртхан хувцас’, *Evk. ‘мужская короткая шуба’*, *Sol. санча* (чамца, чамча) ‘*рубаха*’, *Na. чамча* ‘*халат на вате зимний*’ [383с] гэсэн хэлбэр утгатай ажээ. Энэ үг МНТ (55-р зүйл), Расулидын зургаан хэлний толь, Мукаддимат ал-Адаб толь, Турфаныцуглуулгадахь Махагалын магтаал зэрэг сурвалжид тохиолддог.

Г.Й. Рамстедт энэ үгийн гарлыг *sam (Kor. sam ‘олсны ургамал’) > *samsa > Мо. čamča ‘цамц’ (~ Ma. samsu ‘олсны нимгэн даавуу’) > Ma. Nan. čamči ‘цамц’ (Ramstedt, 1949: 222), И.дө Рахевилц хятад хэлний *shan-tzu* ‘эмэгтэй хүний хувцас, цамц’ гэдэг үгээс гаралтай (Rachewiltz, 2004: 309) гэж тус тус үзжээ. О.Сүхбаатар (207), Д.Төмөртоогоо (333) нар төвөд хэлний *phyam tsha, cham tshe* ‘цээжин биед өмсөх дотуур хувцас’ гэдэг үгээс ирэлтэй гэж үзсэн бол Ц.Элдэндэй “соносхул, энэ үг болбоос итали хэлний čamčia хэмээх үгнээс ирэлтэй хэмээмүй. Турк хэлэнд цамца хэмээх нь 1. дотор цамц, 2. урт энгэртэй тариачны гадар хувцас, турк хүний өмсдөг нэг зүйлийн урт цамцыг хэмээжээ” (Элдэндэй, 1991: 164) гэж тэмдэглэсэн боловч, эх сурвалж заагаагүй байна. Бодвол Ц.Элдэндэй гуай Италийн судлаач Леонардо Ольшки “монгол хэлний čamča нь грек гаралтай бөгөөд франц хэлний chemise, čamičia-тай холбоотой” гэснийг хэлсэн бололтой. Монгол хэлний čamča-ын гарлын талаар Польшийн түрэг судлаач М.Стаховски тусгайлан судалгааны өгүүлэл бичиж, түрэгийн олон хэлэнд цамц, гадуур хувцас зэргийг заасан čamča, samca, čamja, čumča хэлбэртэй үгс байдаг бөгөөд перс хэлнээс түрэгийн хэлнүүдэд нэвтэрсэн samasy(r) ‘дотуур хувцас’ гэдэг үгтэй холбоотой байж болох нэг хувилбар байгааг дурдаад перс-түрэг хэлний samasy(r) нь монгол хэлний samca гэдэг үгийн цорын ганц эх сурвалж биш, Сибирийн хэлнүүдийн samca ~ samsa ~ samzi гэх мэт бүлэг үгсийг өөр өөр үгс хутгалдсаны үр дүн гэж үзэн илүү нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай (Stachowski, 2012: 449) гэжээ. Юутай ч, цамц гэдэг үг хятад, юм уу төвөд хэлнээс орсон үг биш бөгөөд харин эсрэгээр монгол хэлнээс төвөд хэлэнд орсон үг бөгөөд монгол, манж-түнгүс, түрэгийн хэлнүүдэд эртнээс нийтлэг байсаар ирсэн үг ажээ.

цол, Мо. čola, Ma. čolo. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад čola гэдэг үг тохиолддог. Авианы бүтцийг харьцуулбал, čola нь эгшиг ижилсээгүй эртний хэлбэр юм. Түүнээс гадна XVII зууны эхэн үеийн манж хэлээрх албан баримтуудад цол өргөмжилсөн тухайд *gebu buhe* ‘үгчилбэл, нэр өгөв’ гэж найруулсан байдаг. Иймээс энэ үгийг монгол хэлнээс манжид орсон үг гэж үзэх нь зүйтэй.

цуцаа. унаа цуцаа гэдэг хоршоо үгийн цуцаа нь илэрхий монгол үг бөгөөд манж толиудаас нягталж үзэхэд *cusaga* гэдэг манж үг олдсонгүй.

шүүлэнгэ, Мо. siülengge, sigüleng ‘алба гувчуур татаж, хүү сан хамаардаг тушаалтан’. Энэ үгийг Н.Поппе, О.Сүхбаатар нар манж хэлнээс орсон үг гэжээ. Гувчуурыг манжаар *šulehen*, алба гувчуур татахыг *šule-* гэдгээс гадна, энэ үгийн төгсгөл манж хэлэнд түгээмэл хэрэглэгдэх -ngge дагавартай ижил хэлбэртэй (omοform) учраас ингэж үзсэн бололтой. Сэцэнцогтын “Монгол үгсийн язгуурын толь”-д “sigüleng- (хууч.) Алба гувчуур татаж, хүү сан хамаардаг албан тушаалтны нэр. siülengge буюу

šúgúleng ч гэж бичдэг... Жүрчинээр² šulenge гэнэ” (Сэцэнцогт, 1988: 1581), О.Сүхбаатар “Монгол хэлний харь үгийн толь”-доо: “манж. šulenge; Мо. sigúleng; Хуучин цагт алба гувчуур татаж хүү сан эрхлэгч тушаалтан, отгийн даргын орлогч, хар хүн байдаг. siúlengge буюу šúgúleng ч гэж бичдэг. Шүүлэн дэмч гэнэ” (Сүхбаатар, 1999: 265) хэмээн тус тус тайлбарлажээ. Чухамдаа энэ үг Юань гүрний үед хятад хэлнээс орсон үг бөгөөд “shou-ling-a” 守令shǒu lìng, 收令shōu lìng гэсэн ямар нэгэн доод тушаалын албан тушаалтныг илтгэж байсан үг байгаад хожим “татвар хураагч” гэсэн утгатай болсон талаар Х.Серриус тусгайлан судалгааны өгүүлэл хэвлүүлсэн байна (Serruys, 1972).

дуть, Мо. duli хэмээх үг Мо. duta-, dulimaγ, Ма. dulin, dulan зэрэг үг нэг гаралтай дундын үг.

Түүнчлэн мангис, харгаа, сонгино зэрэг үг язгуур ба залгавар бүтээвэр, үгийн бүтцийн үндсэн шинжээрээ монгол үг болох нь тодорхой бол, лайдах, лантуу зэрэг нь хятадаас ормол, шош хэмээх нь төвөд хэлнээс орсон үг болно.

Монгол хэлэнд орсон манж бичгийн хэлний үгс

Үгийн сан бол хэлний хөгжил, харилцан нөлөөллийн хамгийн хөдлөнгө хувьсамтгай түвшин бөгөөд тухайн хэлний үе үеийн түүх, нийгэм, соёлын тусгал, тольдуур болж байдаг. Төрөл бус хэлнүүдийн хоорондох ормол үгсийг бодвол, төрөл хэлнүүдийн хоорондох ормол үгсийг шинжлэн тодруулах нь илүү адармаатай асуудал юм. Тодруулбал, хэлбэр утгын хувьд ижил ойролцоо махбод ихтэй, хэв шинж, үгийн бүтцийн үндсэн шинжийн адил байдал нь зарим ормол үгсийг ялгаж салгахад түвэг³ учруулдаг. Ялангуяа төрөл хэл хоорондын ормол үгс эрт цаг үед хамаарах тусмаа танихад бэрх, зарим нь таних ч боломжгүй юм. Эдүгээ хоёр төрөл хэлэнд нийтлэг байдаг, үгийн язгуур нь хоёр хэлний аль алинд нь байгаа үгсийн нэг хэсэг нь их эртний ормол үг байх магадлалтай.

Үгийн гарал судлал цогцолбор шинжлэх ухааны чанартай байдгийн нэгэн адил манж хэлнээс монгол хэлэнд орсон үгийг судлах нь бичгийн дурсгал, амьд хэлний олон нутгийн аялгуу, төрөл хэлтэй холбогдох үзэгдэл, өөрийн хэлний авиан зүй, хэл зүйн хөгжлийн хуулийн үүднээс тухай тухайн баримтыг цуваа цагийн үүднээс харшуулан түүхэн хэлшинжлэлийн аргаар судлах, түүнчлэн ормол үгс монгол хэлэнд хэрхэн нэвтэрч, хэрэглээ нь бэхэжсэн, утга болон хэлбэрийн хувьд яаж хувирсан, цаг үеийн нийгэм, соёлын харилцааны ямар онцлог нөхцөл байдалтай уялдсан зэргийг тодруулах олон талт шинжилгээг шаарддаг байна.

² Эшлэсэн зохиолд өгүүлсэн жүрчин гэдэг нь манж хэл гэсэн утгаар хэрэглэгдсэн үг.

³ Түвэг гэдэг үг учрах, тохиолдох гэсэн утгатай tube- (кирилээр ‘түвэх’ гэж бичдэг) үйл үндсээс үүссэн учир төвөг гэж бичээгүйг болгооно уу.

Монгол хэлний дурсгалуудыг шүүрдэн нягталбал, илэрхий манж хэлнээс орсон үг тохиолдож байгаа хамгийн эртний дурсгал нь даруй Монголын нууц товчоон болно.

МНТ-нд *niketele* (§123,179), *nenden* (§185), *nendejü* (§200), *nende'esü* (§166, 244) зэрэг хэлбэрээр гарч буй үгс монгол сурвалж, толь бичгүүдэд үл тохиолдох атлаа утга, хэлбэрийн хувьд манж хэлний *nike*- ‘тулах’, *nende*- ‘урьтах’ гэсэн үйл үгстэй яв цав таарч байгаа нь сонирхолтой. Ц.Элдэндэй гуай манж хэлэн дэх МНТ-нд байдаг 160 үгийг түүвэрлэхдээ эдгээр үгийг оруулаагүй байна. Бодвол, манж хэлний баримттай холбогдохгүй гэж үзсэн бололтой. Жишээ нь:

МНТ-ны §123 : *ke'er-ün görö'esün-ü ke'eli inu niketele siqaju öksü qun-u görö'esün-ü quya inu niketele siqaju öksü ba*

МНТ-г судлаачид энэ үгийг *nige/n/* хэмээх тооны нэрийн үндэстэй дуудлага ойролцоод нь дулдуйдаж “нэгдтэл, нийлтэл” гэх зэргээр орчуулах буюу хөрвүүлжээ. Гэвч *-tele* нөхцөлийн өмнөх *nike*- гэдэг үйл үндсийн талаар тодорхой тайлбарладаггүй. Ш.Озава гуай *nige* хэмээх тооны нэрийн үндсэнд үйлийн нөхцөл залгасан ховор тохиолдол байжээ гэж үзсэн байдаг. Чухамдаа *nike*- хэмээх үйл үндэс бол манж хэлний тулах, тулж нийлэх гэсэн утгатай үг юм. Манж бичгийн хэлэнд түших гэсэн салаа утгаар хэрэглэгдэх нь түгээмэл. Мо. *niṗta* ‘нягт’, Ма. *nike*- нэг язгуураас үүсэлтэй байхыг үгүйсгэхгүй.

§200: *bo'ol nekün бүдүн ejen-iyen bosoju nendejü bariqu bolba.*

§166: *aman inu ecige kö'ü ke'ejü amu aburi inu ö're buyu itegejü'ü amui ta ese nende'esü tan-a ya'u bolqu*

Нийт дөрвөн удаа тохиолдох энэ *nende*- гэдэг үйл үгийг судлаачид хажуугийн орчуулгыг нь даган “гэнэдэх” гэдэг үгээр ойлгож, МНТ. *nende*- ~ Мо. *genede*- хэмээх нь нэг үгийн авиа сэлгэж бий болсон хувилбар мэт үздэг. Ингэж нэндэх, гэнэдэх хоёрыг холбож үзэх нь бүтцийн хувьд эргэлзээтэйгээс гадна, уул хам сэдвийнхээ утгад “гэнэдэх” гэдэг үг авцалдахгүй байна. Тодруулбал, уг эхдээ үйлдүүлэх хэвд бичээгүй атал МНТ-ны хөрвүүлгүүдэд *nendejü*-г гэнэдүүлж, *ese nende'esü* гэснийг эс гэнэдүүлбээс хэмээн үйлдүүлэх хэвд оруулж орчуулдаг.

Жишээ нь: §200:	Боол зарц Бодон эзнээ Босож гэнэдүүлж барих болов [128т]
§166:	Ам нь эцэг хүү хэмээх аму Авир нь өөр буюу Итгэж амуй та Эс гэнэдүүлбээс танд юу болох? [92т]

Хэрвээ үйлдүүлэх хэвийн “-үүл” нөхцөл нэмэхгүй байгаа хэвээр нь “гэнэдэж, эс гэнэдвээс” гэж хөрвүүлбэл эхийн утга санаатай зөрчилдөхөд хүрнэ. Тиймээс зарим судлаач түргэлбээс, эс түргэлбээс хэмээн утгачлан буулгасан байдаг. III.Гаадамба *nengde*- ‘хэтэрхийдэх’ гэдэг дүрс ойролцоо өөр үгтэй холбож үзжээ (Гаадамба, 1990: 357). Ц.Элдэндэй, Э.Ардажав нар үзэмчин аман ярианд гэнэдүүлэн дайрахыг нэндэн гэдэг. Алтан хааны туужид гэнэтээр дайрсныг нэндэж хэмээн бичсэн зүйл бий (Eldendei, Ardajab, 1986: 481, 644) хэмээн сонирхолтой баримт бичсэн байна.

Бидний бодлоор манж-түнгүс хэлний “урьтах” гэсэн утгат *nende*- гэдэг үйл үг 13-р зууны үед монгол хэлэнд нэвтрэхдээ ерийн хэрэглээнд бус, харин цэрэг хөдөлгөхтэй холбогдсон нэр томьёо болон хэрэглэгдэж байгаад үзэмчин зэрэг зарим аялгуунд хадгалагдан үлдэхдээ ‘гэнэдүүлэх’-ийг зааж утга нь шилжжээ. Иймд XIII зууны үед Монголын хойд хэсгээр нутаглаж асан гурван мэргид зэрэг монголжсон түнгүс хэл аялгуутнаас “*alginči, nike, nende-, nekün*” гэх мэт цөөвтөр үг нэвтрэн хэрэглэгдэж байгаад хожим мартагдсан байж болох юм.

Бидний бүртгэснээр дараах манж хэлний үгс монгол хэлэнд оржээ. Үүнд:

авга, Мо. *abuγ-a* < Ма. *abuha* ‘*caprella bursa*’⁴, ‘байцайны овгийн нэг зүйл ургамал’, Англ. *shepherd’s purse* (a kind of wild vegetable)

алга, Мо. *alγ-a* ‘загас барих өөш’ < Евк. алга ‘тор’, Sol. алга ‘загас барих тор’, Orch. агга ‘загасны өөш’, Ul. арга ‘загас барих өөш’, Na. алга ‘загас барих өөш’, алга- ‘загасны тор шидэх’, Ма. *alγan* ‘шувуу барих тор’. Эвенк хэлнээс орсон үг бололтой.

алгинч, МНТ §37, 38, 123, 179, 273, 276 дахь *alginči/n* ‘толгойн туршуул цэрэг’, §183, 185, 193, 195, 208 дахь *alginčila*- ‘толгойн туршуулд явах’ гэдэг үгийг Элдэндэй, Ардажав, Д.Цэрэнсодном, Л.Мишиг зэрэг судлаачид манж хэлний *algin* ‘алдар буюу олонд тархсан сайн, муу нэр’ хэмээх үгтэй холбож үзжээ. Sol. алги ‘сонсгол, сураг чимээ’, Ма. *algišambi* ‘цуурхах’. Энэ үг монгол хэлний *aldar* гэдэг үгтэй язгуур нэг бөгөөд эртдээ манж-түнгүс төрөл хэлэнд чимээ ажиг гэсэн утгаар хэрэглэгдэж байсан бололтой ба дээрх судлаачдын үзсэнчлэн XIII зууны үед түнгүс хэлтнээс монгол хэлэнд нэвтэрсэн байж болно. Солоон хэлэнд тэр эртний утга нь хадгалагджээ. Харин манж бичгийн хэлэн дэх ‘алдар’ гэдэг утга нь шилжсэн утга болов уу. Түүнчлэн

⁴ Үгийн тайлбарыг аль болох эдгээр манж үгс монгол хэлэнд орсон цаг үед ойрыг бодож Хааны бичсэн манж үгний толь бичиг, Хорин нэгт тайлбар толь, Хорин наймт тайлбар толь зэргээс авав. Мөн өмнөх илтгэлдээ бид манж үгийн англи орчуулгыг Ж.Норманы толиос авч тавьсан байснаа энд хэвээр үлдээв. Жагсаалтад буй олон үг нэр томьёоны чанартай учир урьд нэгэнтээ хадсан англи орчуулга илүүдэхгүй гэж үзсэн болно.

Sol. алдү ‘авиа’, алдүр ‘мэдээ’, Neg. алдү ‘мэдээ, чимээ’, Ul. алдачй- ‘мэдээлэх, мэдээ авчрах’, Or. алдү ‘мэдээ, сураг чимээ’, Orch. агдиу- ‘сураг мэдээ авчрах, мэдээлэх’ зэрэг үг хийгээд Ma. algin болон Mo. aldar нэг гаралтай, уг үндэс язгуурын утга нь “мэдээ чимээ” гэдэг утгаар нийтлэг болох нь харагдаж байна. МНТ-ны algin-ы учрыг таамаглаж болох өөр нэг хувилбар бол эртний түрэг хэлний elkin ‘аялагч’ хэмээх үг юм. Бидний бодлоор А.Ту. ‘elkin’ нь түрэг, монгол хэлний el ‘харь бус’ гэдэг үгээс үүсэлтэй, утга үүргийн хувьд alginči-тай холбон үзэх боломж бага байна.

амаа, Хөгшин хүнийг үзэмчин аялгуунд amā гэж дуудна (Амаржаргал, 1988: 45). Өмнөд, зүүн монголчуудын хэл ярианд эцгээ хүндлэн дуудахад ингэж хэлэх нь бий.

амбаа, Mo. amba < Ma. amba ‘ахмад хүнийг авгайлах үг’, Англ. big, great, vast, important. Энэ авгайлга үг цахар зэрэг өвөрлөгчдийн аялгуунд их тохиолдоно. Мөн Сүхбаатар аймагт (дорнод халхын аман аялгуунд) лам эцэг гэсэн утгаар хэрэглэнэ. (Амаржаргал, 1988: 45)

амбан, Mo. amban < Ma. amban ‘сайд’, Англ. 1. high official, minister; 2. your servant (used by officials when addressing the Emperor); 3. → amba. Энэ үг утгаа ‘их, том’ гэсэн утгатай. Монгол хэлэнд их-ихэс хэмээн хүн заасан утгатай үг үүсдэг шиг манж хэлэнд amba/n/ ‘их’-amban ‘ихэс буюу сайд’ гэдэг үг үүсжээ. Монгол хэлэнд том, их гэсэн утгатай энэ үг эр үхрийн томхныг заах амбан шар гэдэг үгэнд тохиолддог. Монголчууд Хүрээ, Улиастай, Ховд зэрэг газар суулгаж байсан Чингийн төлөөний сайдуудыг амбан сайд хэмээн хоршин хэлдэг ба олон тоонд амбасын яам, амбас гэх мэтээр хэлдэг байв.

анван, Mo. anvan < Ma. anwan ‘далайн загасны нэр’, Англ. Mandarin fish. «Бие далбаа уухын адил, уухаас урт болоод моголцог» (MGBB: 20-80b)

ангиан, Mo. anggiyan < Ma. anggiyan ‘Далайд төрмүй. Бие нь моголцог, маш сүрхий болоод сүүл нь урт. Сүүлийн дунд нь ясан хутга нэг ургажээ. Хүний гар хөлд оновчоос даруй үхмүй. Хятад ян юй хэмээмүй’ (MGBB: 20-83a), Англ. thornback (a kind of sea fish)

бойдаа, Mo. boyida < Ma. booi da ‘гэрийн дарга’, Англ. officials of the fifth and sixth rank in the Imperial Household. Чингийн үеийн засаг ноёдын ордны аж ахуйн хэргийг эрхлэх даамал. Толь бичигт гэрийн дарга хэмээн орчуулж ирсэн ч манж үгийг нь хэрэглэх нь түгээмэл байв.

бончилго, Mo. bongčiligi < Ma. bončilihi ‘далайн загасны нэр’, Англ. fish from the Eastern Sea whose flesh and bones resemble those of the roe deer.

“Зүүн далайд төрмүй. Мах яс зүрийн адил болоод загасны бие, амт нь их л сайн” (MGBB: 20-79b)

борон, Mo. borung < Ma. murung ‘цоогондой, зэрлэг муур’ “Шилүүснээс бяцхан, малраас иххэнийг нь борон хэмээмүй” (21ТТ: 261)

бошго, Mo. boşoy < Ma. boşoqû ‘улаа хөөгч’, Англ. 1. a driver, a pusher; 2. (領催) corporal. Хэдийгээр хөөгч гэж орчуулдаг боловч энэ үгийг тэр хэвээр хэрэглэж байв.

буу загас, Mo. boo jiyasun < Ma. boo nimaha. Халимын өөр нэр.

бэйл, Mo. beyile < Ma. beile ‘бэйл’, Англ. ruler, Prince of the third rank. Ma. beile < begile < begin. Энэ үгийн эртний хэлбэр begin-ийг жүрчидүүд бүр Алтан улсыг байгуулахаас өмнө хэрэглэж байжээ. Сибирийн түнгүс хэлтэнд Evk. бэyin “1. ахлагч, дарга, 2. эзэн, 3. хадам эцэг (нөхрийн эцэг), хадам ах (нөхрийн ах), 4. хөзрийн ноён, 5. бар”; *бэyin дэyи* “жигүүртний хаан буюу бүргэд”; Ev. бэyн “1. ахлагч, дарга, 2. удирдагч, түрүү (хүн ба амьтны)”; *бэyнтэ* “түрүү ахлагч гэж үзэх”; *бэyс* “ахлах чадвартай”; Neg. бэyin “1. эзэн, 2. ахлагч” гэдэг (Цинциус, 1975: 119) байна. Бас тэдгээртэй хөрш залгаа якут хэлтэнд бэги “өндөр, ахмад” гэсэн утгат үг бий. XVI зуун, XVII зууны эхэн үед Ехэ, Ула, Хада, Хойфа, Жанжүүгийн зэрэг жүрчин аймгуудын тэргүүлэгчийг beile гэж байгаад Чингийн үед вангийн удаах хэргэмийн нэр болжээ. Монголоор ноён гэж орчуулан хэрэглэж байгаад хэргэмийн нэр болсны дараа тэр хэвээр хэрэглэх болсон байна. Гарлын хувьд эртний түрэгийн beg, beu, begi, монголын beki, манж-түнгүсийн begin цол нь гарал нэг, эртний Төв Азийн нүүдэлчдийн нийдэм цол байсан агаад цаашилбал, хятадын Жөү улсын үеэс нааш их, бага янз бүрийн дэсэд хэрэглэж байсан нангиадын 伯бэ (эртний дуудлагыг нь Карлгрен “pak”, Пуллейбланк “pejk” хэмээн тус тус сэргээсэн), солонгост 伯 beg~pak гэдэг цол ч мөн нүүдэлчдээс гаралтай байх магадлалтай.

бэйс, Mo. beyise < Ma. beise ‘бэйс’, Англ. Prince, a Prince of the fourth rank. Угтаа beile хэмээх үгийн олон тооны хэлбэр байснаа хожим хэтэрхий дөрвөн хэргэмийн дөтгөөрхийн нэр болжээ.

гавшгай, ‘шалмаг’ Mo. γabsiyai < Ma. γabsihiyan ‘бушуу цэрэг’, Англ. 1. quick, clever, alert; 2. Vanguard. Цэргийн өмнө мэдээ авах, хэл барих, зам нээх, гүүр барих зэрэгт тушаасан хурц шилдэг цэргийг гавшгай гэнэ. Манж хэлний “γabsihiyan” монгол хэлэнд орохдоо “γabsiyai” хэлбэртэй болжээ. Монгол түүхийн сурвалжуудад “busiyun ~ bisiyun” /бушуу/ цэрэг гэж гардаг. “bisiyun” гэдэг үгийг урьд хурдан түргэнээс гадна, эрч хүчтэй, хөдөлгөөнтэй гэсэн утгаар хэрэглэж байжээ. XVII зууны үеэс “бушуу цэрэг”-ийг “гавшгай” цэрэг гэж манжаар хэлдэг

болсон бололтой. “Гурван зүйлийн үгийг хавсарган зүйл зохиосон бичиг” хэмээх тольд *γabsihiyan*-ыг бас “уулга” хэмээн орчуулжээ. Манжийн габсихияан монгол хэлэнд орохдоо шаламгай гэдэг үгтэй адилсан /аналогиор/ уугуул монгол үг мэт хэлбэртэй болж, улмаар эдгээр ойролцоо үгийн язгуурыг давтсан ‘гав шав хийх’ гэсэн хоршоо үг бий болжээ. *Ma. γabsihiyan, γabtambi* ‘харвах’ зэрэг үг нэг язгууртай үг бололтой.

гацаа, *Mo. γaṣaγ-a* < *Ma. γaṣan* ‘гацаа’, Англ. village, country (as opposed to the city). “Аливаа хот балгасны гадаад хүй хүй суусныг нь гацаа хэмээмүй” (21ТТ: 447)

гингин, *Mo. ginggin* < *Ma. genggiyen duwanse* ‘bright blue satin’ (Розицки, 1994: 88) “Торгоны нэр. Гүн хөх, аргүйг нь гингин хэмээмүй” (21ТТ: 458)

гирд бялзуухай, *Mo. girdü biljuuqai* < *Ma. girdu čečike* < Chin. 吉吊 *jí diào* Англ. a small bird resembling a thrush.

гоцго/гочих, *Mo. γoṣiq-a* < *Ma. γoṣiqa* ‘шадар’, Англ. pertaining to the Imperial bodyguard. Монгол утга зохиолд уг утгаараа тохиолдоно. Тухайлбал, В.Инжаннашийн “Хөх судар”, Ж.Цэвээний “Хөх Монголын хөх туг”-ийн орчуулга болон бусад цөөн бус монгол орчуулгын зохиолд энэ үгийг хэрэглэсэн байна. Мөн “Монголын уран зохиолын дээж зуун билиг” эмхэтгэл дахь “Төр ёсны шашдирын тайлбарт /382-р нүүр/... эзэн богд Тэнгэрийн тэтгэсний гочиха бэйл...гэж гарч байна” (Мишиг, 1972)

гүйлнэй, *Mo. güilnei* < *Ma. guileri* ‘жимст модны нэр’ ‘*Malus prunifolia, Mangifera indica?*’, Англ. plumleaf crabapple, Chinese apple. Монголоор бас хайтан мод, хайтан жимс гэнэ.

гүрэн, *Mo. gürün* ‘гүрэн’ < *Ma. gurun* ‘улс’. *Mmo. güg* ‘хамаг, бүгд’, *Mo. güm* ‘цөм’, *köbči/n/* ‘хамаг бүгд’, *Ma. gubči* ‘бүгд’ хэмээх үгс гарал нэг. Манж хэлний ‘улс’ гэсэн утгатай энэ үг монгол хэлэнд ‘хөвчин улс, гүрэн’ гэсэн утгаар орсон бол, эсрэгээр монгол хэлний *ulus* гэдэг үг манж хэлэнд *ulusu* хэлбэртэй, ‘гүрэн’ гэсэн утгаар оржээ.

гэрди, *Mo. gerüdi* < *Ma. gerudei* ‘эм гарди’, Англ. the female phoenix. Гарди хэмээх санскрит үг монгол хэлнээс манж хэлэнд дам орж, улмаар манж хэлнээ эгшиг сэлгэн хүйс ялгаж *gerudei* хэмээх үг үүссэн нь монгол хэлэнд орсон байна. Монгол хэлэнд манж хэлний адил эгшгийн арга билгээр хүйс ялгах арга байдаг ч, цөөнгүй ийм үгс манж толийг орчуулах явцад даруй оноолтоор бий болсон байдаг.

гиялт, Mo. *giyaltu* < Ma. *giyaltu* ‘*Trichiurus lepturus*’, ‘далайн загасны нэр’, Англ. *largehead hairtail*, a kind of sea fish. “Далайд төрмүй. Хятад бэ дай юй хэмээмүй” (21TT: 461)

давх, Mo. *dabq-a* < Ma. *dafaha* ‘*Oncorhynchus keta*’, Англ. *chum salmon*. “Их нь гурван тохойг өнгөрөхгүй, ам нь тэгш, түрс их, арьсыг өмсөх агуулах зэргийн юм хиймүй” (21TT: 690). Япон тэнгисээс Хар мөрөн өөд орж ирдэг далайн загасны нэр.

дажгүй, Mo. *daji ügei* < Ma. *daljaqu* ‘хамаагүй’, Англ. *unconnected with, unrelated, of no importance*. Энэ үг аман яриагаар дамжин орсон бөгөөд халхын аялгуунд “давгүй, гайгүй, зүгээр” гэх мэт утгаар хэрэглэдэг. Өвөр Монгол дахь зарим аялгуунд далжи ‘хамаа’, далжитай ‘хамаатай’ гэсэн хэлбэрээр бас хэрэглэдэг. Харьцагч этгээдээс талархал илэрхийлэх юм уу, уучлал гуйхад халхчууд зоволтгүй гэсэн утгаар ‘зүгээр’ гэж хариулдаг бол өвөрлөгчид ‘хамаагүй’ гэж хэлдэг нь энэ үгийн үгчилсэн орчуулга юм. Бичгийн зохиолд хаа нэг тохиолдоно. Тухайлбал, “Эрт эдүгээхийн гайхамшиг сайхан үзэгдэл оршивой” нэрт хятадын сонгодог уран зохиолын монгол орчуулгад *dalji* ‘хамаа’ гэдэг үгийг хэрэглэжээ.

дулан, Mo. *dulan* < Ma. *dulan* ‘Хайрсгүй, ам бяцхан, бие гарын алга мэт хавтгай төржээ. Нэг төө хүрэм буй. Арьс маш ширүүн, сум шивэлдэхэд хэрэглэмүй’ (MGBB), Англ. 1. *name of a small sea fish with a small mouth and rough scaleless skin*; 2. *Shark*

дурдан Mo. *durdung* < Ma. *durdun* ‘нэг зүйл бөс’, Англ. *crepe*. “Торгоны нэр. Пансад адил, ширхгийн эрчмийг таталдуулан нэхжээ. Цамц, дотоод хувцсанд хэрэглэмүй” (21TT: 731)

жаргин, Mo. *jargin takiy-a* < Ma. *jargin čoqo* ‘нэг зүйл тахиа’. *Jar+gin* хэмээх бүтцийн *jar* нь бялзуухайн цоргилдох дуу чимээг заасан, манж хэлэнд “*jar jir*” хэмээн хоршин хэлдэг авиа дуурайх үг. *-gin* нь манж хэлний нэр үг бүтээх дагавар.

жинхэнэ, Mo. *jingkini* < Ma. *jingkini* ‘чухам, жинхэнэ’, Англ. 1. *honest, upright, orderly, regular*; 2. *chief, main, principal*; 3. *authentic, legitimate, genuine, true*. Хааны бичсэн манж үгний толь бичгүүдэд *jingkini* гэдэг үг дангаараа толгой үг болж ороогүй, харин холбоо үгэнд тодотгол болж орсон газарт монголоор чухам (*čiqum*) хэмээн орчуулсан байдаг. Жишээ нь: Ma. *jingkini hafan* - Mo. *čiqum tüsimel* г.м. Түүнчлэн 17-р зууны үеийн монгол ном зохиолд жинхэнэ гэдэг үг огт тохиолдохгүй байгаа зэргээс үзвэл хожуу манж хэлнээс орсон үг бололтой.

жинс Mo. *jingse* < Ma. *jingse*. Чингийн үеийн түшмэл малгайн оройн чимэг.

Уламжлалт толь бичгүүдэд очир гэж орчуулсан байдаг ч аман яриа, бичгийн зүйлд жинс хэмээн хэвээр нь хэрэглэж хэвшжээ. Chin. 頂子 dǐng zi гэдэг нь манж үгэнд ойртуулсан үсэг бололтой.

журган, Mo. juryan < Ma. juryan ‘Явдлын Яам’, Англ. ministry, board (an organ of government). Монголоор явдлын яам хэмээн толь бичгүүдэд оноож ирсэн боловч, манж үгийг хэвээр хэрэглэсэн нь үлэмж.

завь, Mo. jabi < Evk. жав ‘завь’, жавпл ‘сал’, жавкән ‘багахан ухмал завь’, жамма ‘банзан завь’, Sol. жавн ‘завь’, Orch. жāви ~ жāи ‘завь’, Ul. жай ‘завь’, Or. жай ‘завь’, Ma. жаја ‘нэг зүйл үйсэн завь’. Үүнийг түнгүс хэлнээс монгол хэлэнд орсон хэмээн В.Розицкийн үзсэнтэй санал нэг байна. Монгол хэлэнд их эрт орсон бөгөөд дундад үеийн монгол хэлнээ хэдийнээ хэрэглэж байсан бололтой.

залан, Mo. jalan < Ma. jalan ‘сумаас дооших цэрэг - засаг захиргааны нэгж’, Англ. subdivision of a banner, ranks. Ma. jalan хэмээх нь угтаа ‘үе’ гэсэн үг бөгөөд манж нар цэрэг-засаг захиргааны нэгжээ зохион байгуулахдаа ҮҮҮ ‘гар’, meiren ‘мөр’, jalan ‘үе’ гэх мэт биеийн хэсэг, эрхтний нэрээр нэрлэсэн байдаг.

замар жимс, Mo. jamur < Ma. jamu “тоорын төрлийн нэг зүйл жимс” “Жимсний нэр. Өнгө улаахан. Амт нь амтайхан, цэцгийн үнэр сайн, өнгө сайхан” (21ТТ: 799)

занги, Mo. janggi < Ma. janggin ‘залан захирагч’, Англ. Secretary in various government organs. Хятад хэлэнд 章京 zhāng jīng <zhāngkīng хэмээх үсгээр тэмдэглэнэ. Зарим судлаач энэ үгийг хятад хэлний 将军 ‘жанжин’ хэмээх үгээс гаралтай гэж үздэг нь эргэлзээтэй. Бас 掌印 zhǎng yìn “tamga barigci” гэдэг үгтэй холбож үзэх нь ч бий.

зая, Mo. jay-a < Ma. jaya ‘нэг зүйл завь’. Mo. jabi, Ma. jahūdai ‘онгоц’, jaha ‘ойм’ язгуур нэг үгс бололтой.

зодон, Mo. jodong < Ma. jodon ‘ороонгоос авсан ширхгээр нэхсэнийг нь зодон хэмээмүй’ (MGBB: 15-8a). Ma. jodo- ‘нэхэх’ +n /үйлээс нэр үг бүтээх дагавар/.

инэнги, Mo. inenggi < Ma. inenggi ‘толгой давхад адил, бие улаан сүүлд адил’ (MGBB:20-83a) далайн загас, Англ. a type of sea fish resembling the sea bream.

ируди, Mo. irüdi < Ma. irudi ‘умардын гарди’, Англ. the phoenix of the north. Үг хураах аргаар бүтсэн манж үгийг толь бичгийн монгол оноолтод тэр хэвээр авчээ. Үүнчлэн Mo. yürüdi < Ma. yurudai, Mo. darudi < Ma. darudai зэрэг хураасан үгийг таван хэлний тольд оруулжээ.

ис торго, Mo. isü < Ma. isu ‘аргүй бараан торго’. Chin. 青素緞 qīng sù duàn.

итэм, Mo. item < Ma. iten ‘тугал’, Англ. a two-year-old cow. Энэ үг Лу. АТ. дахь Чингис хааны билиг сургаалд хоёр удаа, хэрэйдийн Наймалжин эмгэний үгэнд нэг удаа тохиолдож байна.

лагч, Mo. laγsa < Ma. laγsa ‘Толгой лахад адил. Хайрсгүй, хэвэл их, аяга мэт бүдүүн, урт нь гурван төө илүү буй. Элэгний өнгө нь шаравтар болоод загасны элэгнээс маш их’ (MGBB: 20-81a) далайн загас, Англ. Cod

лах, Mo. laq-a < Ma. laha ‘Толгой хамшгар, ам их, сүүлийн этгээд шувтан, хайрсгүй, их нь алд илүү буй’ (MGBB: 20-69a), Англ. 1. straw mixed with mortar, used for making walls 2. Catfish

лиохо, Mo. lioqo < Ma. lioho ‘зэвэгтэй төстэй, цагаан судал бүхий нэгэн зүйл далайн загас’, Англ. a white-striped sea fish, Siberian salmon

лолой, Mo. loloi ‘гахайн шагай’ < Ma. lolo ‘гахайн шагаа’, Англ. the anklebone of a pig (used as a die). Мөн гахай маллаж дуудахад ‘лоолой’ гэж хэлдэг нь энэ үгээс ирэлтэй.

майхан, Mo. mayiqan < Ma. maiqan ‘бөс гэр’, Англ. Tent. Orch. майка(н), Ud. майга, Ul. мајка(н), Na. майка ‘майхан’ (Цинциус нар, 1975: 520)

малуу, Mo. malu < Ma. malu ‘нэг зүйл архины сав’. “Уртачаас иххэнийг нь малуу хэмээмүй” (21ТТ, 1979: 487), “малуугаас нарийхан болоод хүзүү нарийн, амсар бяцханыг нь уртач (Ma.mongγon) хэмээмүй” (21ТТ, 1979: 149) Chin. 瓶 píng

мамууна, Mo. mamun-a < Ma. mamudun ‘молтогчин туулайтай адилавар амьтан’

мармаа сугас, Mo. marm-a suyusu < Ma. marma nisiha ‘Далайд төрөх зарам хэндэлд адил, улаавтар бидэр буй’ (MGBB: 20-84b). Хятадаар 吹沙小魚 буюу үгчилбэл элс үлээгч загас гэнэ.

миегнэх, Mo. meyengne < Ma. meyengne- ‘анги бүлэг болох’. Энэ үгийн талаар проф. Л.Мишиг «Гэлэгбалсангийн нэгэн ерөөлд /591-р нүүр⁵/ “...хахуун тэхүүн өвгөчүүд нь хань ханиндаа миегнэж, ханд хандсаар хэсэлцэж...халамцан тэнчүүрч явах нь...” гэсэн зүйлд миегнэж гэсэн үг гарч байна. Манж хэлэнд анги, бүлэг гэсэн утгатай мэен гэдэг үг бий. Монгол хэлэнд шан гэдэгт «на» дагавар залган шанна болдгийн адилаар дээрх мэен юм уу миен гэдэг үгэнд «нэ» дагавар залган мэеннэ-миеннэ болгон түүнийг ярианы хэлний дагуу миегнэ болгон бичсэн байж болох юм гэж саналаа» (Мишиг, 1972) хэмээн тайлбарласантай

⁵ ‘Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой’ эмхэтгэлийн анхны хэвлэлийн

санал нэг байна.

монгон~мунган, Mo. *mongγan* < Ma. *munγan* ‘бунхан’. Монгол бичиг зохиолд энэ манж үгийг хэрэглэсэн газар цөөнгүй. Тухайлбал, Инжаннашийн ‘Хөх судар’, ‘Боржигид овгийн түүх’-д бунхан хэмээх утгаараа тохиолдож байна.

монди, Mo. *mondi* ‘1. хүлчин чөтгөрийн нэг зүйл, 2. үл бүтэх этгээдийг жигшин дургүйцэхэд хэлэх үг’ (Норжин: 1855) < Ma. *monio* ‘самж’. Энэ үгийг Tib. *mo'dre* ‘эм чөтгөр, эм зэтгэр’ гэдэг үгээс ирэлтэй (Сүхбаатар, 1997: 139; Төмөртоого, 2018: 164) гэж үзжээ. Салгавал төвөдөөр эм, чөтгөр гэсэн хоёр үг болох боловч, хэрвээ бие даасан үгийн сангийн нэгж болгоход хүрвэл харьяалахын тийн ялгалаар хэлбэржүүлэх ёстой. Хэрэглээнд монди гэж голдуу дүрсгүйтсэн бага насны хүүхдийг хэлдэг. Бидний бодлоор манж хэлний *monio* ‘самж’~*bonio* ‘мич’ хэмээх үгээс гаралтай ба сармагчны зулзагатай адилтган монди, монш гэх зэргээр хэлэлцдэг болсон болов уу.

монш, Mo. *monsi* ~ *mondi* < Ma. *monio* ‘самж’. Энэ үгийг Tib. *rmongs zhin* ‘мунхаг, тэнэг мангуу’ гэсэн үгтэй холбож үзсэн санал бий. Чухамдаа монш, монди нэг гаралтай үгс юм.

мүхрүү, Mo. *mükürü* < Ma. *muhuru* ‘чам загасны эм’, Англ. *female sockeye salmon*; cf. *Cime*.

мувь, Mo. *muwi* < Ma. *muvi* ‘*Magnolia kobus*; *magnoliaceae*; *burgeria stellata*’, ‘анхилам үнэрт цэцгийн нэр’, Англ. *lily magnolia*

мураны ав, Mo. *murān* < Ma. *murān* ‘урамдал’. Намар буга орж, урамдах үед хийдэг Манжийн хааны ан авын нэр. Монголоор урамдлын ав гэдэг ч, бичиг зохиолд манж үгийг хэвээр хэрэглэсэн нь цөөн бус тохиолдоно.

мэгж, Mo. *megeji/n/* < Ma. *mehejen* ‘торойлсон эм гахай’, Англ. *sow*. Evk. мэкэжин ‘зэрлэг гахайн эмэгчин’, Sol. мэхэжи ‘гахай’, Ma. *mehun* ‘гахай гэж хараах үг’, *mehen* ‘эм гахай’, *mehe* ‘агт мэгж’, *meheji* ‘хараахан торойлоогүй эм гахай’ (Цинциус нар, 1975: 586). Мин улсын үеийн И й юй бичигт эм гахайг Mo.*mekejin*, Хуа-и и-юй бичигт *mekji* хэмээн тэмдэглэжээ. Мэгж гэдэг үг Мин улсын үед юм уу, түүнээс өмнө монгол хэлэнд орсон манж үг бололтой.

мэйрэн, Mo. *meiyiren* < Ma. *meiren* ‘цэрэг-засаг захиргааны нэгж’, Англ. 1. *shoulder, upper arm*; 2. *on a battue, the two banners marching on both sides of the center*

мэрвин, Mo. *merbeng* < Ma. *merpingge* ‘нэг зүйл нугас шувуу’, Англ. *a name for the common duck*. Зарим тольд марвин гэж бичсэн нь ташаарал юм.

намнах, Mo.namna- < Ma. niyamniya- ‘мориор давхиут харвах’. Evk. н’амн’а- ‘унаа унах’, Sol. нанна- ‘мордон хөөх’, Ev. н’амни- ‘морь, цаа унаж давхих’, Neg. н’амн’а- ‘морь, цаа зэрэг унаа унах’, Ul. н’амн’а- ‘мордох’, Or. н’амн’а- ‘мордож давхих’, Na. нйамниа-‘морь унах’.

ниегз, Mo.niyegje < Ma. niyegje ‘чам загасны эр’

ниүмэр, Mo.niumer-e < Ma.niumere ‘нэг зүйл далайн нялцгай биетэн’, “Далайд төрмүй. Толгой моголцог, хамар харцгайн хамрын адил төржээ. Толгойд ясгүй, биед хайрс хагадас цөм үгүй, найман хөл хойш ургажээ. Сүүл үгүй. Хятад мин фу юй хэмээмүй” (MGBB:20-84a), Англ. Squid

нүхэр давх, Mo. nūker-e dabq-a < Ma. nuhere dafaha ‘эм давх загас’. Эрийг нь атуух давх < Ma. atuha dafaha гэнэ.

нэхлий, Mo.nekelei < Ma.lehele~mehele ‘бутач’. “Эр эрж төрсөн хүүхдийг нэхлий хүүхэд хэмээмүй. Бас бутач хэмээмүй” (21TT: 198). Ma. leheme hehe ‘садар эм’, lehele hūncīhin ‘бутач хамаатан’. l ~ n гийгүүлэгчийн сэлгэцээр монгол хэлэнд nekelei болсон үг бололтой.

нямадан, Mo. nimadan < Ma. nimadan ‘уул завагт ургах нэг зүйл мод’, Англ. a kind of tree that grows in valley groves and produces a hard, fine-grained wood

оо, Mo. ou-a (ow-a) < Ma. ufa ‘гурил’. И.Захаровын тольд тайлбарласнаар ufa нь гурил гэсэн утгаас гадна тутаргын гурилаар хийсэн оо (*пудра изъ рисовой муки*)-г бас хэлдэг гэжээ. Г.Д.Санжеев нар үүнд үндэслэн монгол хэлний оо (ow-a) гэдэг үгийн гарлыг Ma. ufa-тай холбосон ба улмаар монгол хэлнээс хасаг хэлэнд опа хэлбэрээр орсон гэж үзжээ. (Санжеев нар, 2016: 218)

олом, Mo. olom ‘гол гатлах гүйхэн газар’ < Ma.olombi ‘ус гатлах’. Манж хэлний үйл үндсэнд монгол хэлний нэр үг бүтээх -m дагавар залгаж olom хэмээх үг үүсжээ. Уг монгол үг нь yarum ‘гарам’. Манж хэлэнд olombi ‘явган ус гатлах’, doombi ‘унаагаар гол гатлах’ хэмээн ялгаж хэлдэг байна. Ma. olosi ‘гарамчин’, ološon ‘шалбуур буюу хөлөөс бүсэлхий хүртэл үргэлж хийсэн ус гатлахад өмсөх арьсан өмд’, olongdo ‘усанд өмсөх урт түрийтэй гутал’ зэрэг үг olo- язгуураас үүсжээ. Түнгүсийн олон төрөл хэлэнд olo- язгуурт үгс буйг манж хамниган хэлний харьцуулсан тольд (Цинциус нар, 1977: 15) тэмдэглэжээ.

олонгодой, Mo. alongyodoi < Ma. olongdo ‘Гуянд хүрүүлэн хийсэн урт түрийтэй гутлыг олонгодой хэмээмүй. Бас гарум хэмээн дуудмуй’ (MGBB: 15-67b) Ma. olo- ‘гатлах’ → olo-ng-do хэмээн бүтжээ. Монгол

уг нэр нь гарам (γar+/u/m) бөгөөд манжаар бас ‘γarun’ (< Мо. γarum) гэнэ. Ма. γarun < Мо. γarum = Ма. olongdo > Мо.olongyodoi

омбол, Мо. ombul < Ма. omolo ‘ач’, Англ. grandson.

ор, Мо. oru < Ма. oron ‘цаа буга’ Академич Б.Ринчен монгол хэлэнд ор гөрөөс, ор буга хэмээн манж хамниган хэлний үг хоршин хэлдгийг дурдсан байна. [Ринчен, 2015: 26]. Түнгүсийн хэлнүүдэд бугыг орон, оро, оро̄ гэх зэргээр хэлнэ.

оронго, Мо. orongyo < Ма. orongyo ‘нэг зүйл гөрөөс’. “Зээрэнд адилхан, баахан бяцхан, эвэр урт болоод хавтгай, өнгө бараан” (21ТТ: 114).

орим, Мо. orima < Ма. orima ‘шанхан загас’ (Ц.Норжин, 1997: 430), Англ. the name of a sea fish that resembles the burbot.

орхоодой, Мо. orqodai < Ма. orhoi da ‘хүн өвсний үндэс’, Англ. ginseng; cf. orhoda

пиүлэх, Мо. piüleke < Ма. fiyeolehe ‘Далайн дотоод нэгэн зүйлийн загас. Толгой, биеийн хайрс цөм их, алтан хацарт адил’ (MGBB: 20-82b), Англ. a type of sea fish with large scales

пял, Мо. pila < Ма. fila ‘жигжиг таваг’, Англ. a plate. “Тавгаас бяцханыг нь пял хэмээмүй” (21ТТ: 289)

сагамхай, Мо. sayamq-a < Ма. sahamha ‘sea perch’. Далайн алгана загас. “Урт нь нэг алд илүү буй” (21ТТ: 526)

сам хорхой, Мо. sam < Ма. samra. “Зарам загасны нам. Сахал урт, хөл үлэмж, хоёр хавчуур буй. Биед үе үетэй хальс буй” (21ТТ: 530).

согоц, Мо. соуџу < Ма. sohočo “Алтан хацарт адил” (MGBB: 20-82b) далайн загас, Англ. the name of a variety of sea fish similar to the yellowcheek.

суйх, Мо. suyiq-a < Ма. suiha ‘шарилж’, ‘artemisia aurentea’, Англ. artemisia, моха, sagewort; Ма. suiha хэмээх үг suwayan буюу шар өнгө заасан үгийн su- язгуураас үүссэн бол, монгол хэлний siralji ‘шарилж’ нь ‘шар’ гэдэг үгийн sira үндэснээс үүссэн байна. Манж хэлний нэр үг бүтээх -ha дагавар бүтээц ихтэй, ялангуяа амьтан, ургамлын нэрд их тохиолддог. Энэ үг монгол хэлэнд орж, эдүгээ шарилжийн нэг зүйлийг заасан нэр болжээ.

сумаран, Мо. sumarang < Ма. sumari ‘нэг зүйл шувууны нэр’, Англ. the name of the goatsucker in Sichuan; cf. simari cecike

сэлэгз, Мо. selegje < Ма. selegje ‘төмөр идэшт домгийн амьтан’. Ма. sele

‘төмөр’ хэмээх үгээс үүссэн манж үг.

сэлэм, Mo. selm-e < Ma. seleme ‘илд’, Англ. a dagger somewhat larger than a dabcilakū and carried at the belt.

тагт, Mo. taytu < Ma. taytu ‘асар, давхарлаг гэр’, Англ. 1. storied building, tower; 2. Upstairs. “Баганыг өндөр болгож дундуур нь хавтгай мод дэвсэн хоёр зэрэг, эсвээс гурван зэрэг болгон ташаалсан давхар гэрийг тагт хэмээмүй” (21ТТ: 623). Neg., Ul., Or. такту ‘амбаар, пин’, Na. такто/ý/ ‘амбаар, агуулах’, Ma. taytu ‘давхарлаг, цамхаг, майхан, тагт’ (Цинциус нар, 1977: 154).

тайхуа, Mo. tayiquva < Ma. taihûwa ‘Хайгад адилхан далайн загас’, Англ. sea-bream

тайюн, Mo. tayiün < Ma. taiyün “Хайгад адил. Баахан моголцхон” (MGBB: 20-82b)

тамаа, Mo. tam-a < Ma. tama ‘далайн загас’, Англ. sole (a kind of fish), flatfish. “Далайд төрмүй. Хятад сөзи ди юи хэмээмүй” (21ТТ: 623)

тамтан, Mo. tamtan < Ma. tamtan. “Давхралын адил, далбаа улаан” (21ТТ: 624) далайн загас. Orch. тамта, тамтака, Ud. тамича ‘тамтан’.

танхим < Ma. tanggin. Хятад хэлний 堂 tang дээр манж хэлний -gin дагавар залгаж бүтсэн үг. “Албан хэрэг шийтгэх газрыг танхим хэмээмүй” (28ТТ: 1455)

таншиг, Mo. tangsiy < Ma. tangsiy ‘нэг зүйл араатан амьтан’, Англ. the name of animals. “Инлиншань ууланд гармуй. Янз барсад адилхан, сүүл нь биеэс урт, бар ирвэсийг идмүй” (28ТТ: 1457)

тармин нугас, Mo. tarmin nuγusu < Ma. tarmin niyehe, Evk. тармй ‘нугас’, Neg. тајмй ‘нугас’, Orch. таумæ ‘нугас’, Ud. таумæ ‘нугас’, Ul. тармй ‘нугас’, Na. тармй ‘нэг зүйл нугас’. Нэг зүйл нугасны энэ нэр уламжлалт манж монгол толь бичгийн оноолтоор монгол хэлэнд орсон байна.

тах, Mo. taqu < Ma. taqu ‘загасны нэр’, Англ. tench (fish) “толгой их моголцог хайрс нарийн, хошуу тэгш. Тах гурван зүйл боловч, асар ялгагдахгүй. Тарган нь амт сайн” (MGBB: 20-66b)

тахар, Mo. taqar < Ma. taquran ‘зарлага’, Англ. commission, duty, mission, task, official post

таянга, Mo. tayungy-a < Ma. tayungya ‘Цагаан амар загас мэт буй. Хайрс нарийн, толгой амар загасны толгойноос нарийхан’ (MGBB: 20-81b),

Англ. the name of a sea fish that resembles the carp

тосгон, Mo. *tosqu/n/* < Ma. *toγso* ‘тосгон’, Англ. village. “Тариалан үйлтгүүлэн хүн суулгасан газрыг тосго хэмээмүй. Жич, тосго дүл хэмээн холбож хэлэлцмүй” (21ТТ: 661)

тугдам/тутам, Mo. *tuγtam* < Ma. *tuγtan* ‘анх’, Англ. 1. beginning; 2. originally, at first, for the first time. Монгол хэлний тугаар, тулгар зэрэг үгтэй язгуур нэг байж магадгүй. Ярианы хэлэнд “анх тутам” гэж хоршин хэлдэг “тутам” нь “тусам, бүр” гэсэн утгатай тутам биш, энэхүү ормол үгийн нэг хувилбар дуудлага юм.

тугуй~дугуй, Mo. *duγui* < Ma. *doohan* ‘гүүр’, Англ. Bridge. “Ганц модоор тавьсан гүүр” (Норжин нар, 1999: 2630)

турлиах ~ турлааг, Mo. *turliyaq-a* < Evk. туракй ‘хэрээ, алаг туу’, турлакй ‘улаан хошуут’, Ma. *turaki* ‘хар хэрээ, турлааг’, Sol. турāки ‘улаан хошуут’, Neg. *torāxī* ‘хэрээ, турлааг’, Ev. турāки ‘хэрээ’ (Чимитдоржиева, 2012: 80). Угтаа монголоор туруу (*turuu*) хэмээх боловч, эдүгээ ярианы хэлэнд турлиах гэх болсон нь эвенк хэлний үгийн хэлбэр буриад аялгуу, улмаар халх аялгуунд нэвтэрчээ.

түрээс, Mo. *türiyesü* < Ma. *turigen* ‘үнэ’, *turihe* ‘үнэлсэн хүч’, *turimbi* ‘биеийн хүч үнэлэх’. Розицки манж хэлний Ma. *turigen* < Mo. *türiyesü* гэжээ. Бид манж хэлнээс монгол хэлэнд орсон гэж үзэж байна.

тэнхим, Mo. *tingkim* < Ma. *tinggin* ← [Chin. *Ting* + Ma. *-gin*]. Үүнчлэн хятад үгэнд манж хэлний *-gin* дагавар залган шинээр үүсгэсэн *tanggin* ‘танхим’, *laŋ* + *gin* → *nanggin* ‘халхавч’ гэх мэт үгс буй.

уух, Mo. *ouq-a* < Ma. *ooha* ‘*Siniperca chuatsi*’, ‘загасны нэр’, Англ. mandarin fish, Chinese perch, бас анван гэнэ.

үеэ, Mo. *üy-e* < Ma. *uye* ‘Бие тулд адил, бидэр зэвгийн адил болоод өнгө цагаавтар’ (MGBB: 20-83a), Англ. white catfish

үй, Mo. *üi jiyasu* < Ma. *ui nimaha*, ‘Бие тулын адил. цагаан эрээн толбо буй. Урт дөрвөн төө үлмүй’, Англ. flying fish

үхүүр, Mo. *üküri* < Ma. *ukuri* ‘далайн загас’. “Зүүн далайд өөдөлмүй. Амт нь давхаас эрхэм. Янз нялгарт адил. Хайрс нарийн” (21ТТ: 174).

үюү, Mo. *üyü* < Ma. *uyu* ‘нэг зүйл далайн загас, далайн яст мэлхий’, Англ. 1. the name of a sea fish 2. turquoise.

хаван, Mo. *qavan* < Ma. *hafan* ‘түшмэл’, Англ. official rank

хайга загас, Мо. qayü-a < Ма. haihüwa ‘Бие хавтгай болоод өргөн, хошуу эртгэр, хайрс нарийн’ (MGBB: 20-68b) далайн загас. Англ. bream

хайчин, Мо. qayičin < Ма. haičin ‘шонхор шувуу’, Англ. the peregrine falcon; Манж хэлэнд бас šongqon < Мо. šongqur хэмээх үг бий. Аль алийг нь хоёр хэлнээ шонхор шувууны зүйл ялгах нэр болгож хэрэглэхээр толилсон бололтой.

хала-, Мо. qala- ‘солих, ээлжлэх’ < Ма. qala- ‘солих, улирах’. Ма. hala-, Neg., Oroch., Ud. кала-, Ul., Or., Na. қала- (Цинциус, 1975: 364), Sol. хала-, Jur. hala- ‘солих, сэлгэх’. А.Вовин энэ үгийг монголоос манжид орсон гэж үзсэн Г. Рамстедт, В.Розицки (Rozycki, 1994: 99), С.Старостин (Старостин нар. 2003.1: 636) нарын саналыг няцааж, XVII зуунаас өмнөх монгол хэлээрх бичвэрүүдэд энэ үг тохиолддоггүй, харин жүрчинээс аваад бусад түнгүсийн хэлнүүдэд байдгийг дурдаад Чингийн үед манжаас монгол хэлэнд орсон үг гэж үзэв. Тэр бээр манж хэлнээс дагуур хэлэнд орсон үгийг таних нэг шалгуур бол манж ормол үгэнд гарч ирдэг тохируулга гэмээр урт эгшиг юм хэмээн Д.Кара-гийн нотолсныг мөн үндэс болгон Dag. kālā- гэдгийг дурджээ (Вовин, 2014).

халим, Мо. qalimu < Ма. qalimu, ‘Буу загасыг халим хэмээмүй. Маш их, хэд хэдэн хос алд нь буй. Толгойн дээр нүх буй, ус үсрэх бөгөөс **суваргын** мэт дэгдмүй’ (MGBB: 20-78a), Англ. Whale.

халфини, qalfini < Ма. qalfini “далайн загасны нэр. Янз шааврын уланд адил. Нэг этгээдэд хайрс буй. Нэг этгээд төвшин болоод харйсгүй. Хоёул хавсарсан хойно сая явмуй. Хятадаар би мү юй хэмээмүй” (20-83b)

ханин, Мо. qanin < Ма. qanin ‘далайн байцай’ “Далайн цагаан ногоог бас ханин хэмээмүй” (21ТТ, 1979: 296). Хятадаар 海帶 hǎidài гэнэ.

хачин, Мо. qačin ‘жигтэй, сонин’ < Ма. hačin ‘зүйл’, Англ. kind, sort, class, item. Ма. sonin hačin (холбоо үг) → Мо. sonin qačin (ойролцоо утгат хоршоо үг) → Мо. qačin ‘жигтэй, этгээд’ хэмээн хачин хэмээх үгийн утга өөрчлөгдөн монгол хэлэнд нэвтэрсэн гэж үзэв.

хижим, Мо. kijimi < Ма. kijimi ‘далайн нэг зүйл нялцгай биетэн’, Англ. trepang, sea slug.

хондого, Мо. qondoyo < Ма. hontoхо ‘хагас’. Зуун тавин эр цэрэг гаргаж үл хүрэх хагас сумыг хондого гэнэ.

хосох, Мо. qosq-a < Ма. qosha ‘Нэг зүйл далайн загас’. Англ. globefish, swellfish. “Далайн загасны нэр. Янз шанаган хорхой адилхан, өөө цагаан, нуруу ногооворхон болоод шар зурдас буй. Нүдээ цавчлан чадмуй. Цусыг арилган засахгүй болбоос идвээс эндэгдмүй. Хятад хэ

тун хэмээмүй” (21ТТ: 384).

хотон, Mo. qotan < Ma. qûtan ‘хотон шувуу’, Англ. a name for the pelican; cf. kûtan. Монголчууд дээхэн үед хотон шувууг хорьдой хэмээн түрэг гаралтай үгээр хэлж байгаад хожим манж хэлний адил хутан гэх болжээ. Кирил бичгээр анх буулгахад хутан бус хотон хэмээнээр энэ дуудлага нь хэвшсэн байна.

хошой, Mo. qoşoi < Ma. hoşoi ‘нутаг чөлгийн, мужийн, өнцөг зовхисын’, Англ. 1. corner, angle; 2. area, region; 3. direction. Энэ үгийн талаар хойно дэлгэрэнгүй тайлбарласныг үзнэ үү.

хуаран, Mo. quvaran < Ma. qûwaran ‘хороо’, Англ. camp, barracks

хулан, Mo. qulang < Ma. hûlan ‘Зуухын утаа гарах зэргийг хулан хэмээмүй’ (21ТТ: 399) Сэцэнцогт энэ үгийг uniyar ‘униар’, ungʷasqu ‘унгасах’, uᠩᠭᠢᠭᠢᠴᠢ ‘уугих’ зэрэг үгтэй нэг *hu- гэсэн язгууртай гэж үзжээ. Үүнийг үгүйсгэхгүй ч дурдсан үгийг манж хэлнээс ормол үг гэж үзнэ.

хундага, Mo. qunday-a < Ma. hûntaha ‘хундага’, Англ. cup, mug, glass. Манжаар нүдний ухархайг мөн ‘yasai hûntahan’ буюу үгчилбэл нүдний хундага гэж адилтган хэлнэ.

хурандаа, Mo. qurangda < Ma. qûwaran-i da ‘хорооны дарга’, Англ. a commander elected by the officers of a camp.

хуувь, Mo. quubi /хэбэй, Mo. kebei < Ma. hebei ‘зөвлөлийн’, Англ. 1. consultation, deliberation, planning. “е” эгшгийг уруулшуулж хэлдэг өвөрлөгчдийн аялгууны онцлогоор монголжуу дуудлагыг quubi хэмээн бичиж заншжээ.

хуужих, w.mo. quujiq-a < Ma. qoojiha “Ла түн хэмээх загасыг хуужих хэмээмүй” (MGBB: 20-82b), Англ. dolphin, porpoise.

хүнд, Mo. < Ma. kundu ‘зангийн дараа тушаал’, Англ. respect, honor, respectful.

хүр, kûr-e < Ma. kure ‘амарт адил болоод хамарт хүртэл толгойн дээгүүр цөм хайрс ургажээ. Мах маш доорд муу’ (BGBB: 20-67b)

хүрц, Mo. kûrče < Ma. kurče ‘далайн цагаан загас’, Англ. the name of a white sea fish that resembles the fu nimaha. “Далайд төрмүй. Хятад бэ гао юй хэмээмүй” (21ТТ, 1979: 439).

хүрэм, Mo. kûrm-e < Ma. kurume ‘цээжээр өмсөх хувцас’, Англ. a coat or garment worn over one’s other garments. Na. курмэ ‘арьсаар хийсэн цээжээр өмсөх охор гадуур хувцас’, Bur. хүрмэ, хүрмэг ‘гадуур өмсөх

үслэг хүрэм’

хэбэй, хуувийг бас хэбэй хэмээн уг хэвээр нь хэлж бичих явдал бий.

хэнгин, Mo. kenggin < Ma. henggin ‘далайн амьтан’, Англ. Tardigrade. “Өтөгт адил болоод загасны бие. Суман онгоц үүнд их л цээрлэмүй” (21ТТ: 343).

хэндэл сугас, mo. kendel-e suγusu < Ma. kendele nisiha ‘Далайд төрөх зарам давхад адил’ загас (MGBB: 20-84b).

хэргэм, Mo. kergem < Ma. hergen ‘хэргэм’, Англ. rank, title. В.Розицки энэ үгийг монгол хэлнээс манж хэлэнд орсон үг гэж үзсэн нь үндэслэлгүй юм. Энэ үг утгаа ‘үсэг’ гэсэн манж үг болно. Ханзны тухайд үсэг нь даруй үг, нэр хэмээх ухагдахуунтай адил. Сайд түшмэдийн зэрэг дэвийг илтгэх үгийг өргөмжлөл, жуух бичгээс аваад тамга тэмдэг, аливаа баримт бичигт тавих тул утга нь шилжиж, зэрэг дэвийг ялгасан нэрийг мөн “hergen” гэх болжээ. “Үе залгамжлах түшмэлийг хэргэм хэмээмүй. Бас түшмэл хэргэм хэмээн холбож хэлэлцмүй” (MGBB).

хэрмээ, Mo. kerme < Ma. kerme ‘Давхарлын адил, өнгө ногоовтор (MGBB: 20-82a) /далайн загас/, Англ. a sea fish resembling the tubehe (tubehe: Hemibarbus labeo: Amur barbell)

хэрмээн, Mo. kermeyen < Ma. kermeyen ‘Цагаан зармын адил төржээ. Маш тарган, урт нь хоёр төө илүү (MGBB: 20-81b) далайн загас’, Англ. a sea fish similar to the heihule (heihule: a small round fish with a small mouth, possibly a kind of dace).

цолгорох, Mo. čolyora- < Ma. čolyoro- ‘хэтийдэх’, Англ. 1. towering, lofty; 2. prominent, surpassing, excelling. Монголын утга зохиолд энэ үгийг цөөнгүй хэрэглэх ба čolyoram-а ‘цолгором’ гэдэг тэмдэг нэр үүсжээ. Mo. čol ‘уул хадны хэтэрхий өндөр товгор байдал’ (Sečenčoytu, 1988: 2268) хэмээх үгтэй гарал нэг.

цув дээл, Mo. čuba degel < Ma. čuba sijigiyan ‘босоо магнагаар хийсэн нэг зүйл эхнэр хүний дээл’.

цуух, Mo. čuuq-a < Ma. čooqa ‘цэрэг’, Англ. 1. army, troops; 2. soldier; 3. military, martial. Энэ үгийн талаар хойно дурдсаныг үзнэ үү.

чам, Mo. čim-a, Ma. čima ~ čime ‘далайн загасны нэр’. “Зүүн далайгаас өөдөлмүй. Үгүүрт төстэй. Янз давхад адил. Эрийг нь ниегз хэмээмүй. Эмийг нь мүхрүү хэмээмүй” (21ТТ: 768).

чичугаа, МНТ. §76, 77, 78, 125 čiču’а. Ш.Шиотани “Монгол хэлний малиа

ташуур «whip» хэмээх үгийн гарал үүслийн тухай” гэдэг өгүүлэлдээ МНТ-д 4 удаа гардаг ṣīcu’a гэдэг үгийн гарлыг Jur. sušiha, Ma. šusiha, Sib. susxa, Evk. jisug, Orch. ʃiʃaw, Hej. tʃutʃa зэрэг манж түнгүс хэлний ‘ташуур’ гэсэн утгатай үгстэй холбож үзээд тухайн үеийн монгол, манж-хамниган соёлын харилцааны ул мөр гэж үзсэн байна. Мөн монгол төрөл хэлнүүдээс монгол хэлэнд ṣɕzau ‘ташуур’ гэдэг хэлбэртэй тохиолдож байгааг дурджээ (Шиотани, 2004: 104-105).

шанхан загас, Mo. šangqan jiyasu < Ma. šangqan nimaha. “толгой том, сүүл нарийн, ам их, эрүү доороо нэг сахалтай, далайд амьдардаг нэг зүйлийн сагамхай. Мах нь амттай. Элэг нь том учраас аж ахуйд өргөн ашиглагдана. Бас орима гэдэг” (Норжин нар, 1999: 2167).

шингнэх, Mo. singne- < Ma.simne-. «Нарны Гэрэл дагинын туужид /236- р нүүр/ “... гэрийн эзэн минь хааны хотод ноён шингнэх гэж ирсээр таван жил болов гэх мэтээр ноён шингнэх, ноён шингнах, ноён шингнэнэм гэх мэт үг тохиолдож байна. Энэ үг манж хэлний симнэмби /шалгана/ гэсэн үг байна» (Мишиг, 1972). Наран гэрэл дагинын туужийн манж хувилбар ‘Мин ши хунгийн бичиг’ нэртэй бөгөөд харгуулан тулгаж үзвэл, Наран гэрэл дагинын туужийг тэрхүү Мин ши хунгийн бичгээс орчуулсан нь илт мэдэгддэг.

шохин нугас, Mo. šokin nuṣusu < Ma. šokin niyehe ‘нэг зүйл нугас шувуу’. Энэ үг хятад гаралтай, манжаар дамжин монгол хэлэнд орсон үг.

эдэн, Mo. edeng < Ma. edeng. Нэг зүйл далайн махчин загас. Хятадаар 水虎 shuǐ hǔ буюу усны бар гэнэ.

элбэх, Mo. elbe- ‘хамжиж туслах < Ma. elbi- ‘элсэх’, Англ. to summon, to call together, to invite, to win over to one’s own side, to muster, to recruit (troops). Элбэх гэдэг үг илтгэх утгыг нь бодвол, монгол сурвалж, ном зохиолд цөөнгүй хэрэглэгдэх боломжтой үг. Гэвч хуучин ном зохиолд таарахгүй байна. Манж хэлний elbi- ‘элсэх’ гэдэг үг ярианд хамсах гэсэн утгаар орсон байж магадгүй.

элбэнх, Mo. elbengkü < Ma. elbihe ‘Nyctereutes procyonoides’, ‘амьтны нэр’, Англ. raccoon-dog. Evk. элбиүэ ‘элбэнх’, элбинэ ‘дорго’.

элж, Mo. elje ‘загасны түүш ба түүшийн яс’ (Norjin, 1999: 243) < Ma. elje ‘халимын сэрвээ яс’, Англ. baleen.

элжэн нум, Mo. eljen numu < Ma. elje beri ‘Буу загас буюу халимын сэрвээгээр хийсэн нум’.

эрин, Mo. erin < Ma. erin ‘цаг’, Англ. time, season. “Хавар, зун, намар, өвлийг дөрвөн цаг хэмээмүй. Бас нэг өдөр, нэг шөнийг арван хоёр цаг

хэмээмүй. Тэр хэм, энэ учрыг төн тэр цаг, энэ цаг хэмээмүй” (MGBB; 21TT, 1979: 744). Sol. эрй ‘цаг, удаа’, Ev. эри ‘цаг’, neg. эжун ‘цаг, хугацаа’, Orch. эрү/н/ ‘цаг’, Ud. эли/н/ ‘цаг, хугацаа, цаг болох’, Ulch. эру/н/ ‘цаг, хугацаа, үе’, Or. эри/н/~эру/н/ ‘цаг, хугацаа’, Na. эр, эрй ‘цаг, хугацаа’, Жүр. ‘óh-lín ‘цаг улирал’.

эфү, Mo. efü < Ma. efu ‘хүргэн’, Англ. Imperial son-in-law. Манж хэлэнд үндсэн утгаараа хүргэн ах, жич хадам ах ба хадам эгчийн нөхрийг эфү гэнэ. Чингийн үед хааны гүнжтэй холбосон эрийг бас эфү гэж байсныг монголоор тавнан гэнэ. Дотор нь улсын тавнан, хошой тавнан, төрийн тавнан, хошууны тавнан хэмээн зэрэг дэс тогтоожээ. Академич Б.Ринчен манжийн efu болон монгол хэлний ebügen хэмээх үг гарлын хувьд холбоотой гэж үзсэн байдаг. “Монгол хэлнээс гаралтай эцэг, өвгөн гэдэг үгийг хамниган манж аймгийн хүмүүс, нөхрийнхөө талын эцэг буюу нөхрийнхөө ахыг, манжид эбүгэ гэсэн монгол үгний эбү гэдгийг нь эфү гэж ахмад хүргэнээ хүндэтгэн нэрлэдэг үг болгосныг нь хянан ажвал, монголчууд эрт дээр цагт хамниган манжаас эмс охид олзлон гэргий хийдэг байсны гэрч болж байна. Тэгээд хамниган эмэгтэйчүүд нь төрсөн эцгийгээ хамниганаар нэрлээд, монгол нөхрийнхөө эцгийг этки-эткий гэх болж, охины талынхан нь монгол хүргэнийхээ эцгийг хамниганаар нэрлэхгүй, охиныхоо нэрлэдгээр нь этки-эткий хэмээн дуудаж, хамниган хэлнээ тэр монголын эчиге-этиге гэдгээс уламжилсан этки-эткий нь хүргэн хүүгийн эцэг, чингээд монгол бичигт эбүген гэдэг үгийн эртний хэлбэр эпүкен-епүкен гэдгийн эпү-епү нь эфү болон, манж хэлнээ ахмад хүргэн хүү тэгээд хожмоо бүр хаан хүний хүргэн гэсэн утгатай үг болж ирсэн...” (Ринчен, 2015: 127-128). Үүнийг зөвшөөрвөл Mo. *epügen ~ epüken > Ma-Tung. epü ~ efu → Ma. efu > Mo. эфү хэмээн үг хувьсан урвуу орсон (reborrowing) үзэгдэл болжээ.

ягшуур, Mo. yaɣsiyur < Ma. yaɣsi- ‘хаах’ + yur (V → N). “Хаалга үүд хөших модыг ягшуур хэмээмүй” (21TT: 842). Түүнчлэн Хорчин аялгуунд хаалга хаах, түгжихийг “ягсаалгах” гэж хэлдэг нь манж хэлнээс орсон үг юм.

яц, Mo. iča < Ma. iča ‘Heemisanx prognathus’, ‘жараа овгийн хайрсгүй нэг зүйл загас’, Англ. a kind of long white, ocean fish with no fins - called the ‘noodle, fish’ in Chinese. “Далайгаас өөдөлмүй. Хятадаар мянь тiao юй хэмээмүй” (21TT: 93).

Эдгээрээс гадна манж-түнгүс хэлнээс орсон үг байхыг үгүйсгэх аргагүй ч нотлоход бэрх цөөнгүй үгс байна. Жишээлбэл: Mo. jayarin ~ jayirang ‘зайран’ ↔ Ma. jarimbi ‘тамлах буюу бөө удган онгодоо залбиран дуудах’, Mo. doruyu ↔ Ma. doryon ‘дорго’, Mo. asar ↔ Ma. asari ‘асар’, Mo. sümüsü

↔ Ma. sumusu ‘сүмс’, Mo. kerem ‘хижиг өвчин’ ↔ Ma. kerī ‘хижиг өвчин’, Mo. quril ‘хэрмийн үүр’ ↔ Ma. hūri ‘самар’, Mo. sisi ‘шиш’ ↔ Ma. šušu ‘шиш’, Mo. tomila- ↔ Ma. tomila- гэх мэт.

Манж хэлнээс орчуулсан элдэв бичиг зохиолд орчуулалгүй хэвээр хэрэглэх, эсвэл монгол үгтэй хоршин хэрэглэсэн манж үг нэлээд тохиолддог. Жишээ: манж хэлнээс орчуулсан Юань улсын сударт “*čungnaqui degermedeküi*”, “*singnegülküi bayurayulqui*”, “*γayili čifun*” (Ma. *čuwangna*- ‘дээрэмдэх’, *singnebu*- ‘шалгуулах, шалгадагт оруулах’, *čifun* ‘гааль’) гэсэн хоршоо үг тохиолдож байна.

Зарим үг язгуур гарлын хувьд монгол ба манж хэлний дундын үг мөн боловч, тухайн тодорхой үгийн хэлбэр, утгаараа яах аргагүй Чингийн үеийн нийгмийн онцлогийг тусган орж ирсэн үгс байна. Тийм үгийг бид ормол үгээр авч үзэх нь зүйтэй гэж үзэв. Жишээ нь: *amban* гэдэг үг манж, монгол хэлнээ нэгэн адил том, их гэсэн утгатай. *Амбан шар* гэдэг холбоо үгэнд ордог. Гэтэл ихэс хэмээх утга шилжин албан тушаал заах болсон *amban* гэдэг нэр томьёог монгол хэлэнд сайд гэж орчуулахын сацуу амбан сайд хэмээн хоршиж хэлэх нь бий. Тэгвэл энэ үг эрх тушаалтныг заасан нэрийн хувьд ормол үг юм. Нэг үгэлбэр нэг утгалбар илтгэж, тус тус үгийн сангийн нэг нэгж болох тул үгийн сангийн нэгж гэсэн утгаар ормол үгийг тооцох нь зүйтэй.

Бид монгол хэлээрх түүхэн болон бусад сурвалж бичиг, албан бичиг захидал, толь бичгүүдэд дээр жагсаасан үгс чухам хэдий үеэс тэмдэглэгдэж эхэлснийг боломжийн хирээр байцаан сурвалжилсан бөгөөд тэдгээр нь 17-р зууны үеэс, ихэнх нь 18-р зуунаас эхлэн монгол хэлээрх бичиг зохиолд тохиолдож байгаа юм.

Монгол хэлэнд орохдоо дан үгээр бус, хэвшсэн холбоо үгээр нэвтрэн, улмаар утга нь хувирсан онцгой тохиолдол байна. Тухайлбал, “сонин хачин” гэдэг хоршоо үг монгол хэлэнд харьцангуй саяхнаас хэрэглэгдэж эхэлжээ. Одоогоос хоёр гурван зуун жилийн тэртээ монгол хэлэнд ийм хоршоо үг байсан гэх баримт үгүй. Угтаа “**хачин**” хэмээх нь манж хэлний зүйл гэсэн утгатай үг болно. 18-19 дүгээр зууны үеийн манж, монгол захидал бичгийн уламжлалд захидлын төгсгөл хэсэгт манжаар “*γūwa sonin hačin aqū*”, монголчилбол “өөр сонин зүйлгүй” хэмээх тогтсон үгийг хэрэглэж байжээ. Одоо ч монголчууд захидалдаа түүнчлэн бичсэн хэвээр. Манж хэлний сонин зүйл гэсэн утгатай “*sonin hačin*” гэсэн холбоо үгийг уул хэвээр нь хэрэглэсээр тэр нь яваандаа монгол хүнд ойролцоо хоршоо үг шиг ухагдахад хүрчээ. Сонин, хачин хэмээх хоёр үгийн үеийн бүтэц, үгийн төгсгөлийн ижил нийтлэг байдал үүнд түлхэц болсон байна. “Сонин хачин” гэдэг холбоо үг ийнхүү аажмаар монгол хэлний ойролцоо утгат хоршоо үг мэт хэвшихдээ “хачин” хэмээх манж үгийг “ер

бус, этгээд, өвөрмөц” гэдэг утгаар сэтгэх монгол үг болгон хувиргажээ. Түүнчлэн хачин гэдэг ормол үгийг “сонин” хэмээх үгийн адилтгалаар үг бүтээх, үг хувилгах үндэс болон хэрэглэх болов. Тухайлбал, сонирхолтой - хачирхалтай, сонирхох - хачирхах гэх мэт. Монгол хэлний “сонин” гэдэг үг нь сонь, содон, сонор, соохолзох, сортойх зэрэг үгтэй үндэс язгуур нэгтэй, гарцаагүй монгол үг болох нь тодорхой. Гэтэл “хачин” гэдэгтэй гарал нэгсэх оор монгол үг үл олдохоос гадна, “Монголын нууц товчоо”, “Хураангуй Алтан товч”, “Эрдэнийн товч”, “Чакраварти Алтан хааны тууж” болон бусад 18 дугаар зуунаас урагших монгол хэлний дурсгалуудад энэ үг тохиолдохгүй байна. Багцаалбал XIX зууны эхэн үеийн орчуулга гэж бидний таамаглаж буй “Эрт эдүгээхийн гайхамшиг сайхан үзэгдэл хэмээх судар” хэмээх Сүн, Юань, Мин улсын үеийн элдэв жигтэй явдлын тухай аман хуучийг эмхэтгэсэн хятадын сонгодог уран зохиолын монгол орчуулгад хачин хэмээх үг нэг ч тохиолдсонгүй, харин ойролцоо утгатай жигтэй, сонин гэх мэт үг хэрэглэжээ.

Өвөр Монголын Их Сургуулийн профессор Го.Зоригтын “Монгол хэлэн дэх зээлэг үгийг ялган тогтоох нэг аргын тухай” өгүүлэлдээ дурдсанчлан тухайн хоршоо үгэн дэх бүрдүүлбэр нь 1. Дангаар бие дааж хэрэглэгдэж байгаа эсэх, 2. Илтгэх утга санаа нь ил тод мэдэгдэж байгаа эсэх /бахь байдаг г.м./, 3. Үг бүтээх чадамж нь хэр байгаа, 4. Холбоо үг үүсгэх чадамжаар хир зэрэг байгаа, 5. Монгол бусад хэл аялгуунд байгаа эсэх зэргээр шалгуур хийж монгол хэлний ормол үгсийг ялган үзэх нь зүйтэй (Joriytu, 1999: 27-41) гэдэгтэй бид санал нэг байна. Урианхадай Хүрэлбаатар: “Манж хэлнээс монгол хэлэнд орж ирсэн үгийн олонх нь биеэ дааж хэрэглэгдэхээс гадна, бас нэгэн хамтын онцлогтой байдаг. Тэр нь юу вэ гэвэл, түүнтэй адил буюу ойролцоо утгатай монгол хэлний уугал үгтэй хамт хоршоо үг бүтээдэг бөгөөд тэгэхдээ монгол хэлний үг нь өмнө нь, манж хэлний үг нь хойно нь байршдаг. Жишээлбэл: цэрэг цуух, цаг эрин, дэмий балай, ховор хомс гэх мэт. Ингэж өөрийн хэлний үгийг өмнө нь, өөр хэлний үгийг дараа нь байршуулдаг заншил байсан бололтой. Иймэрхүү нийтэч онцлог түгээмэл оршиж байх эсэхийг цаашид үгийн гарлыг судлах ба тодлоход анхаарч үзэж болох магадгүй” (Kürelbayatur, 2014: 13) хэмээн сонирхолтой ажиглалт хийснийг мөн дурдалтай.

Зарим манж ормол үгийг монгол хэлний хэлбэр дүрс ойролцоо өөр үгтэй нэг үндэстэй мэт ухан утга хувиргасан тохиолдол ч байна. Жишээлбэл, хошой гэдэг үгийн тухай өмнө нэгэн өгүүлэлд тайлбарласнаа сонордуулъя. Чингийн үед *hošoi čin wang* “хошой чин ван”, *hošoi efu* “хошой тавнан”, *hošoi gege* “хошой авхай”, *hošoi gungju* “хошой гүнж”, *hošoi fujin* “хошой хатан” гэх зэрэг цол байв. Энэ манж, монгол хэлний “hošoi ~ хошой”-г зарим толь бичигт бичсэнчлэн хоёр удаагийн, давхар гэсэн утгат үгээр ухаарч үл болно. Тэгээд ч “хошой тавнан” бол хоёр удаа гүнжтэй холбосон хүн биш, “хошой чин ван” бол хоёр удаа чин ван

өргөмжлөгдсөн гэсэн үг биш нь тодорхой. Японы судлаач Абэ Кацуо энэ үгийн гарлыг хошуу гэдэг үгтэй холбосон аж⁶. Тэнгэрийн сүлдэтийн үед анх hošoi beile “хошой бэйл” гэдэг цол гарсан бөгөөд найман хошой бэйл найман хошууг захирч байжээ. Энэ hošoi гэдэг нь манж хэлний өнцөг, зовхис гэсэн утгат hošo хэмээх үгийн харьяалахын тийн ялгал дахь /hošo-i/ хэлбэр юм. Hošo гэдэг үгийг өнцөг, зовхисоос гадна хязгаар чөлгө нутаг гэсэн утгаар хэрэглэж байв. Эзэн хаан буюу улсыг төвлөн захирагчид хажуугаас түшин тус тусын хошууг захирагч гэсэн утгаар найман зовхисын бэйл гэж нэрийдсэнээс энэ үг гарчээ. Өөрөөр хэлбэл, хаан (төв) ↔ хошууны эзэн (зовхис) гэсэн утгын харьцаатай байна. Дээд эрдэмт /Ch’ung-te/-ийн үед хошой бэйл гэдэг цолыг халж, оронд нь хошой чин ван зэрэг цолыг бий болгов. Ердийн чин ван, тавнан ... зэргээс хошой гэсэн тодотголтой нь илүү зэрэгтэй байдаг тул яваандаа мөнөөх хошой гэдэг маань монголчуудад хүч нэмсэн, хоёр удаагийн гэсэн шиг утгаар ухагдахад хүрчээ. Үүнд нь, qosiyaд “хошоод”, qosi “хош” гэсэн монгол үгсийн гадаад хэлбэр ойролцоо нь нөлөөлсөн байна. Чингээд, hoso-i гэсэн манж үгтэй ижил хэлбэртэй (омоним), хоёр удаагийн, давхар гэсэн утгат монгол үг бий болсон ба манайд “хошой баатар”, “хошой аварга” гэх мэтээр хэрэглэж иржээ. “Qošoi” хэмээх үгийг монгол хэлний үүднээс бүтээврээр нь задлахад задалж болохгүй, qosi- үндэс байх ёстой атал qošo- болчихсон байдаг нь чухамдаа хошой ба хошоод нь хоёр өөр гаралтай үг учраас тэр юм.

Тухайн хэлний үг нөгөө хэлэнд орж, тэр хэлний онцлогт зохицон хувьсаж өөрчлөгдөөд, тэр хувирсан хэлбэр утгаараа эргээд уул эхний хэлэндээ орох тохиолдол байна. Дээр өгүүлсэн хошой гэдэг үг бол тийм урвуу ормол (re-borrowing) үгийн жишээ юм. Үүнд: Мо. qosiya ‘шувуу амьтны хошуу → өнцөг бүхий гурвалжин дүрс → цэргийн түрүү, магнай → засаг захиргааны нэгж’ > Ма. hošo ‘өнцөг, зовхис’, Ма.hošo+i beile, hošo+i čin wang, hošo+i efu ‘хэргэм зэргийн нэр’> Мо.qošoi ‘хэргэм зэргийн нэр → хоёр дахь удаагийн’ гэсэн хэлбэр, утгын хувирал гарчээ. Товчхондоо, монгол хэлний хошуу гэдэг үг манж хэлэнд орж, хэргэм зэрэг заасан нийлмэл үгийн бүрэлдэхүүнд харьяалахын тийн ялгалаар хэлбэржин орсон нь тэр хэвээр монгол хэлэнд оржээ. Хожим хэргэм зэргийн нэрс түүхэн үг болж орхигдох үест, өнөөх тийн ялгалтай хэлбэрийг нь хоёрын тоог заасан хо- язгуурт өөр үгстэй “будилан” төрөлсүүлж “хоёр удаагийн” гэсэн утгатай үг болгон хэрэглээнд оруулжээ.

Харьцуулж буй хоёр төрөл хэлэнд адилхан нэг гаралтай төрөл үгс ч ормол үг байж болно. Тодруулбал, хоёр хэлний аль алинд ижил язгуур, үндэстэй үг байвч, тухайн нэг тодорхой хэлбэр, илтгэх утгаараа нэг хэлнээсээ нөгөө хэлэнд орсон үг байж болно. Жишээлбэл, хятан хэл

⁶ Энэ мэдээг [Kanda Nobuo.; On the *Beile* 貝勒 of the Early Ch’ing Dynasty // The Tōyō Gakuhō Reports of the Oriental Society, vol.XXXX. No. 4. March 1958. 7p.] өгүүлээс дам авав.

хийгээд дундад үеийн монгол хэлний *ša'ur* < *ša'ur* 'аян дайн', *ša'ur/a/-* 'аялах, дайлах', Манж түнгүсийн хэлнүүд дэх цэрэг гэсэн утгат *Ma. šooḥa*, *Ewk. чоѳа*, *Sol. чоѳа*, *Neg. чавха* ~ *чау́ха*, *Or. чау́ха*, *Na. чао́ха* зэрэг үгс гарал нэгтэй дундын үг юм. Гэвч, монгол хэлний цэрэг цуух гэдэг хоршоо үгэнд орсон цуух бол манж хэлнээс орсон үг юм. Өөрөөр хэлбэл, гарлаараа дундын үг тул ормол үг биш гэж болохгүй. Үүнчлэн *Ma. amban*, *beile*, *beise*, *meiren*, *gurun* зэрэг үг монгол үгстэй нэг язгуур гаралтай боловч, тухай тухайн тодорхой хэлбэр утгаар нь авч үзвэл манж хэлнээс монгол хэлэнд орсон үг болно.

Дээрх жагсаалтад буй үгс нь уламжлалт манж-монгол толь бичигт байгаа болон Монгол улсад хийгээд Өвөр монголд нийдэм нэвтэрсэн гэж болох үгс юм. Эдгээр нийдэм үгсээс гадна, нутаг нутгийн аялгуунд нэвтэрсэн манж хэлнээс ормол үгс цөөнгүй байна. Монгол хэлний нутгийн аялгуунуудад манж үг хэр орсон нь харилцан адилгүй ажээ. Ц.Норжины “Монгол хэлний толь”-д:

анияа (*Mo. aniy-a*) 'цагаан сар' < *Ma. aniya biya* 'цагаан сар'
 анияах (*Mo. aniyaqu*) 'цагаалах' < *Ma. aniyalambi* 'шинэлэх'
 анияачин (*Mo. aniyačin*) 'шинэлж яваа хүмүүс' < *Ma. aniya inenggi*
 'шинийн нэгэн' + *čin*
 агуур (*Mo. aγur-a*) 'зэвсэг' < *Ma. aγûra* 'зэвсэг'
 амбаа (*Mo. amba*) 'эцгийн үеийн эрэгтэй хүмүүсийг хүндлэх дуудлага'
 < *Ma. amba* 'их, ихэс'
 адах (*Mo. adaqu*) 'үндсэн тушаалын хажуугаар өөр тушаалд хавсран хариуцах' < *Ma. adambi* 'дашлах, зэрэгцэх'
 агдах (*Mo. aγdaqu*) 'эрэмших' < *Ma. aγdambi* 'итгэх'
 амаа (*Mo. am-a*) 'эцгээ өргөн дуудах үг' < *Ma. ama* 'эцэг'
 шарах (*Mo. siraqu*) 'залгамжлах' < *Ma. sirambi* 'залгах'
 хал (*Mo. qala*) 'овог' < *Ma. hala* 'овог'

гэх мэт өмнөд болон зүүн монголчуудын хэл аялгуунд манж хэлнээс орсон үг толгой үг болон оржээ (*Norjin nar*, 1999).

Боржигин Баярмэнд “Монгол хэлний нутгийн аялгууны өвөрмөц үгсийн судлал” бүтээлийнхээ “Нутгийн аялгуун дахь өвөрмөц үгсийн толь” хэсэгт:

Chah. ama: 'эцэг, өвгийн үеийн ахмад хүнийг хүндлэн дуудах үг' < *Ma. ama* 'эцэг'
de:m 'инээдэм, шог' < *Ma. demun* 'ов'
udʒ 'бөхийн уралдааны манлай' < *Ma. uju* 'тэргүүн'
ɕʒa:ɕ 'бөхийн уралдааны дэд' < *Ma. jai* 'дэд'
a:ga: 'ах хүнийг хүндлэн дуудах үг' < *Ma. age* 'авгай, ах хүнийг хүндлэн дуудах үг'

ad- ‘эгнэрэх, зэрэгцэх’ < Ma. adambi ‘зэрэгцэх’
 amba: ‘эцэг, өвгийн үеийн эрэгтэй хүнийг хүндлэн дуудах үг’ < Ma. amba ‘их’
 andʒi: ‘эцгийн үеийн эрэгтэй хүнийг хүндлэн дуудах үг’ < Ma. amji ‘их авга’
 aʃa: ‘бэргэн’ < Ma. aʃa ‘бэргэн’
 məjəŋ ‘бүлэг, үе’ < Ma. meyen ‘анги’
 Baa. diber ‘үнэг, чонын зулзага’ < Ma. deberen ‘зулзага’
 Sh.bar. dobtɔŋ ‘захидлын уут’ < Ma. dobtɔŋ ‘дугтуй’
 dzusaŋ ‘зураас татахад хэрэглэх шугам’ < Ma. jusuqû ‘зуралт, шугам’
 ɔjɔŋGo ‘чухал, чухаг’ < Ma. oyongyo ‘чухал’

зэрэг үг манж хэлнээс орсныг тодруулжээ⁷. Тэр бээр «Цахарчуудын хэл ярианд манж зээллэг үг илүү байдаг» хэмээн онцолсон байна. Тус зохиолд сурвалжлан цуглуулсан нутгийн аялгууны өвөрмөц үгсээс мөн дараах үгс манж хэлнээс орсон үг болох нь тодорхой байна. Үүнд:

Sh.bar. aŋGal ‘гэр бараа, гэр бүл’ < Ma. angʷala ‘ам’ ɔŋ ‘нэн, улам’ < Ma. hon ‘огоо, маш’
 Kh.bar. adʒig dzalo: ‘өчүүхэн дүүрэн’ < Ma. ajige jalu ‘өчүүхэн дүүрэн’
 boigəŋ ‘эд хөрөнгө’ < Ma. boiɣon ‘өрх, сан’
 dʒalaŋ ‘үе, үе удам’ < Ma. jalan ‘үе’
 lax ‘ханз’ < Ma. nahan ‘ханз’
 njɔrgaŋ ‘гэрэл зураг’ < Ma. niruʷan ‘зураг’
 xoda: ‘үнэ ханш’ < Ma. hūda ‘үнэ’
 Chah. əjəŋgə: ‘эгчийн үеийн хүмүүсийн хүндэтгэл дуудлага’ < Ma. eyungge ‘эгчмэд’

Г.Гантогтох “Баргын аман аялгууны үгсийн сангийн бүрэлдэхүүний онцлог” хэмээх илтгэлдээ «Баргын аман аялгууны үгсийн сангийн бүрэлдэхүүнд Алтайн хэлний нийтлэг үгс уламжилснаас манж, эвенк, нанай, солоон, орчоон, зүрчид гарлын үг идээшин тогтнож хэвшээд, он удаан жилд улиран хэрэглэгдсээр иржээ» (Гантогтох, 2011: 242) гээд дараах үгсийг жишээ болгожээ. Үүнд:

ангал ‘гэр бүл’ < Ma. angʷala ‘ам’
 байт ‘албан бичиг’ < Ma. baita ‘хэрэг’
 гальдаа ‘гарын дарга’ < Ma. ʷalai da ‘гарын дарга’
 далж ‘энэ чамд ямар далжтай юм бэ’ < Ma. dalji ‘хамаа’
 жалан ‘үе’ < Ma. jalan ‘үе’
 лайган ‘залхуу’ < Ma. laiɦu ‘гөрч’
 мухандаа ‘өвгийн ахлагч’ < Ma. mukûn i da ‘төрлийн дарга’
 няхарах ‘хятадаар ярих’ < Ma. nikarambi ‘хятадаар ярих’

⁷ Галиг, үгийн тайлбарыг зохиогчийн бичсэнээр оруулав.

оёнго ‘чухаг’ < Ma. oyongyo ‘чухал’
 ташига ‘сургууль’ < Ma. tašikū ‘сургууль’
 угардаа ‘бүгдийн дарга’ < Ma. uheri da ‘бүгдийн дарга’
 үгмээ ‘авга бэргэн’ < Ma. uhume ‘авга бэргэн’
 хал ‘овог’ < Ma. hala ‘овог’

Ууда нарын “Барга аман аялгууны үгс”-д мөн дараах үгсийг манж гаралтай гэжээ.

anaḡaŋ dʒil ‘илүү жил’ < Ma. anayān ‘илүү’
 aŋa:gi:ŋ xə:l ‘сар шинийн идээ’ < Ma. aniya ‘жил’
 ŋorgaŋ ‘гэрэл зураг’ < Ma. niṛuyan ‘зураг’
 bi:rəŋk < Ma. bireku ‘хүвэр мод буюу гурилын элдүүр’
 bi:rəŋkəd- ‘хүврээр гурил элдэх’
 xal < Ma. hala ‘овог’
 ga < Ma. giyai ‘зээл, гудамж’
 lax < Ma. laha ‘наалдуур буюу байшин шавардахад хэрэглэх мушгимал өвс’
 ləʃiŋ < Ma. langse ‘буртаг’
 məŋʊ < Ma. bonio ‘мич’
 taʃxoi < Ma. tašiqū ‘сургууль’ (Uuda, 1983)

Барга аялгуунд Өвөр Монгол дахь бусад аялгуунаас илүү манж үг орж, манж бичиг зохиол дэлгэрч тархсан байдгийн нэг шалтгаан нь тэдний өвөг дээдэс анх Хөлөнбуйрт нүүдэллэн очих үест баргачуудын дунд монгол бичигтэн, монгол судар ном харьцангуй цөөн байсантай холбоотой байж магадгүй. Хожим Баргын бичгийн хүмүүс монголоор төдийгүй манжаар зохиол бүтээлээ бичсэн нь цөөнгүй билээ.

Судлаач Гуй Фан «Түүхэн тэмдэглэлийг үндэслэвэл Юань улс байгуулагдсанаас Чин улсын Энх-Амгалан хаан сууринд суусан дундач үе болтолх 400 жилийн турших хугацаанд Шивэй үндэстэн нийдэм Монголын эрхшээлд байж, ялангуяа Хорчин монголчуудтай нягт харилцаатай байжээ» (Gui Fang, 2012) хэмээн онцлоод энэ хугацаанд хорчин аялгуунд орсон хэдэн шивэй, манж үгсийн тухай өгүүлэл нийтлүүлсэн байна. Мөн Сю Хуа “Монгол хэлний Хүрээ яриан дахь зээлэг үгийн тухай”, Тулгуур, Сэргэй нар “Жарууд хошууны монголчуудын төрөл садны өвөрмөц дуудлагаас шинжлэх нь” зэрэг өгүүлэлд тухай тухайн нутгийн аялгуун дахь манж ормол үгсийн талаар дурджээ.

Монгол хэлнээс манж хэлэнд орсон үгсийг цаг хугацааны хувьд тодорхой мэдэгдэж буйгаар нь хэлбэл хятан хэлний үеэс авхуулаад Чин гүрний үед хамаарах ба утгын хувьд байгаль, нийгмийн олон салбарт хамаарах өргөн ба явцуу хэрэглээний үлэмжхэн үг байна. Манж хэлний мал аж ахуйн холбогдолт үгсийн дийлэнх нь монгол хэлнээс орсон үг байдаг.

Тэгвэл манж хэлнээс монгол хэлэнд орсон үгс их төлөв XVII-XIX зууны үед орсон, утгын орноор нь үзвэл, загасны нэр, хэргэм зэрэг, тушаал, засаг захиргааны нэгжийн нэр зонхилж байна. Гол мөрний болон далайгаас гол мөрөнд ирдэг нүүдлийн загасны нэрс монгол, манж хэлэнд нийтлэг дундын үг байхаас гадна, нэлээд нь тус тус өөр нэртэй ажээ. Харин далайн загас, далайн амьтан, ургамлын монгол нэрсийн хувьд манж гаралтай үгс зонхилж байна. 1708 оны “Хааны бичсэн манж үгний толь”-ийн 1717 оны монгол орчуулга буюу Хорин нэгтийн толь нь монгол хэлний тайлбар толиудын суурь толь болсон бол, хожмын 5000 орчим үг нэмсэн “Хааны бичсэн манж монгол хятад гурван зүйлийн аялгуу нийлсэн толь бичиг”, “Хааны бичсэн дөрвөн зүйлийн үсэг хавсарсан манж үгний толь бичиг”, “Хааны бичсэн таван зүйлийн үсэг хавсарсан манж үгний толь бичиг” зэрэг зүйл хуваасан толь бичгүүд нь орчуулгын толь төдийгүй, мөн нэр томъёоны толийн чанартай билээ. Тухайн толь бичгүүдийг найруулахдаа толгой үгийг орчуулалгүй орхиж болохгүй тул монгол хэлэнд дүйх үгс нь байхгүй далайн загас, далайн амьтан, монгол газар байдаггүй ургамал амьтны нэрс, хятадын домог үлгэрт гарах амьтны нэрсийг монголоор оноож өгөхдөө манж үгийг тэр хэвээр нь болон ялимгүй өөрчилж авах, үгчлэн орчуулах, үг хурааж шинэ үг бүтээх зэрэг аргыг хэрэглэсэн байдаг. Үүнтэй холбоотойгоор монгол хэлний үгийн санд манж гаралтай далайн загас, амьтны нэр цөөнгүй бий болж, хожмын монгол хэлний толь бичгүүдэд дам дам тусгагдсаар ирсэн байна. Хэрэгцээ шаардлагаас шалтгаалан ийм үгсийн зарим нь идэвхгүй, зөвхөн толь бичгийн үг төдий, зарим нь амьтан, ургамал судлал зэрэг салбарын нэр томъёо болон хэрэглэгдэж байхад зарим нь нийтээр мэдэх ерийн үг болон хэрэглэгдэж байна.

Товчилсон үгс

Хэл аялгуу:

Баа.	Баарин аялгуу
Bur.	Буриад аялгуу
Chah.	Цахар аялгуу
Chin.	Хятад хэл
Evk.	Эвенк
Ev.	Эвен
Jur.	Жүрчин хэл
Kaz.	Хасаг хэл
Kir.	Хиргис хэл
Khak.	Хакас хэл
Ma.	Манж бичгийн хэл
Mo.	Монгол бичгийн хэл

Na.	Нанай хэл
Neg.	Негидал хэл
Or.	Орок хэл
Oroch.	Орчоон хэл
Kh.bar.	Хуучин баргын аялгуу
Sib.	Шивэй хэл
Sh.bar	Шинэ баргын аялгуу
Sol.	Солоон хэл
Tuv.	Тува хэл
Ud.	Үдэгэ хэл
Uig.	Уйгур хэл
Ul.	Ульч хэл

Ном зохиол:

АНТ	Асрагч нэргийн түүх
MGBB	Manju gisun-i buleku bidhe /1717 он/
MHT	Монголын нууц товчоон
Лу.АТ	Лувсанданзаны Алтан товч
ХАТ	Хураангуй Алтан товч
21ТТ	Хорин нэгт тайлбар толь
28ТТ	Хорин наймт тайлбар толь
Э.То	Саган сэцэний Эрдэнийн товч

Резюме

В статье автор предлагает для уточнения более реальной картины исследования данной темы необходимым в первую очередь установить иноязычные заимствования для обоих языков, далее уточнить активное взаимодействие монгольского и маньчжурского языков. Так же автор в разделе “Научный обзор” изложил свое положение о заимствовании из маньчжурского языка в монгольский опираясь на уже существующих исследований учёных и свое разногласие о некоторых слов.

В основной части статьи автор изложил положение своего исследования в соответствии данного исследования приведены более 150 слов в качестве примера, заимствованных из маньчжуро-тунгусского языка в монгольский язык. При осуществлении задачи исследования были проштудированы и отобраны слова и на основе этого привлечены лексические параллели маньчжурского и монгольского языков из разного отрезка времени, глоссарии, индексов. Также апробирована возможность заимствования из третьего языка. Согласно источнику, чтобы различить заимствования из маньчжурского в монгольский язык необходимо

учитывать возможность лексического разбора слова, историческое развитие фонетики монгольского и маньчжурского языков, процессы исторического развития морфемы сравниваемых языков, помимо того, необходимо учитывать духовную сторону данной проблемы, это соприкосновения в области истории, культуры, литературы обоих народов.

Ном зүй

Амаржаргал, Б. (1988). *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг*. I. Халхын аялгуу, А-В. Улаанбаатар.

Аюушжав, П. (1992). Монгол хэлэнд орсон манж үгийн тайлбар, орчуулга. *Орчуулгын тухай өгүүлүүд*. Улаанбаатар. №2. X. 7-10.

Ayusijab, P. (1998). *Mongyol kelen-dür oroysan manju yaraltai üges*. Mongyol kele bičig. Öbür Mongyol-un Arad-un Keblel-ün Qoriy-a. №259-64.

Bayarmendü. (2010). *Mongyol kelen-ü nutuy-un ayalyun daki öbermiče üges-ün sudulul*. Öbür Mongyol-un Yeke Surayuli-yin Keblel-ün Qoriy-a. Kökeqota. ISBN 978-7-81115-810-6.

Баярсайхан, М. (2002). Монгол хэлээрх “Дайчин улсын магад хууль”-ийн хэлний онцлогоос. *Mongolian studies*: №12. *The Korean Association for Mongol Studies*. Seoul. X. 91-96.

Баярсайхан, М. (2008). Жүрчин ба манжийн зарим цол хэргэмийн учир (засаж нэмсэн 2 дахь хэвлэл). *Acta Mongolica*, VIII (306). X. 89-104.

Vovin, A. (2014). *Borrowing of verbal roots across language family boundaries in the 'Altaic' world*. *Altai Hakpo* 24. P. 151-161. The Altaic Society of Korea.

Гаадамба, Ш. (1990). *Монголын нууц товчоон*. Улаанбаатар. X. 442.

Гантогтох, Г. (2011). Баргын аман аялгууны үгсийн сангийн бүрэлдэхүүний онцлог. “Баргын түүх, соёлын судалгаа” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. Улаанбаатар. X. 241-246.

Gui Fang. (2012). *Qorčin aman ayalyu ba sibegе kelen deki jarim neyite dumdayin üges-ün tuqai*. Öbür Mongyol-un Neyigem-ün Šinjilekü Uqayan. №3. X. 47-50.

Dayula. (2006). *Manju kelen deki mongyol jigelege üges-i ijil yarultai üges-eče ilyaqu ary-a jarčim*. *Mongol Sudulul-un бүтүгел-үн čiyulyan*. Öbür Mongyol-un Yeke Surayuli. Kökeqota. №1. X. 160-170.

Doerfer, G. (1985). *Mongolo-Tungusica*. Wiesbaden.

- Захаров, И. (1875). *Полный маньчжурско-русский словарь*. Санктпетербургъ.
- Joriytu, Го. 1999, Mongyol kelen deki jigelege üge-yi ilγan toytaγaqu nige arγ-a-yin tuqai. *ÖMIS, erdem sinjilegen-ü sedkül*. №4. Kökeqota. X. 27-41.
- Ковалевски, О. (1849). *Монгольско-Русско-Французский словарь*. Казань.
- Kotwicz, W. (1938). Le Elements Mongols Dans le Mandchou. *Rocznik orientalistyczny* 14. P. 91-102.
- Kürelbayatur, U. (2014). 18-duγar jaγun-ača qoyisi mongyol kelen-dü jigelegden oroγsan manju kelen-ü üge. *Öbür Mongyol-un Yeke Surγayuli-yin Erdem sinjilgen-ü sedkül. Gün uqayan neyigem-ün sinjilekü uqayan (Journal of Inner Mongolia University, Philosophy & Social Sciences (Mongolian Edition))*. Kökeqota. №1. X. 5-14.
- Ligeti, L. (1960). *Le Ancient Elements Mongols Dans le Mandchou*. AOH 10. P. 231-248.
- Manduqu, Ö. (1995). *Mongyol I-iui toli bičig*. Ündüsün-ü keblel-ün qoriy-a. Begejing.
- Мижиддорж, Го. (1982). Гаплогения в лексике монгольского и маньчжурского письменного языков, Теоретические проблемы Восточного языкознания. М. ЧЗ. С. 100-106.
- Мижиддорж, Го. (1974). *Манж монгол бичгийн хэлний хураасан үгийн учир*. Улаанбаатар: ШУАХ, 2/10/ боть, 3-р дэвтэр.
- Мижиддорж, Го. (1964). *Манж-монгол хэлний ижил язгуурт үгийн толь бичиг*. Эрдэм шинжилгээний өгүүллүүд. 4-р боть, 16-р дэвтэр. Улаанбаатар.
- Мишиг, Л. (1969). «Манжүи яргиян кооли» хэмээх бичигт гардаг зарим монгол үгийн тухай. *МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг*. №26. Улаанбаатар. X. 28-31.
- Мишиг, Л. (1972). Монгол бичгийн хэлэнд орсон зарим нэг манж үгийн тухай. *МУИС, Эрдэм шинжилгээний бичиг*, №41, 39-45-р тал.
- Мишиг Л. (1973). О некоторых монгольских словах вошедших в маньчжурский письменный язык. *ОУМЭИХ 2, 1-р боть*. Улаанбаатар. X. 308-312.
- Mostaert, A. (1968). *Dictionnaire Ordos*. Seconde edition. New York-London.
- Norjin, Mang. Mören. (1999). *Mongyol kelen-ü toli*. Öbür Mongyol-un Arad-un Keblel-ün Qoriy-a. X. 3142.

Патаева, В.Д. (2015). Тунгусо-Маньчжурские заимствования в бурятском языке. Теоретические и методологические вопросы изучения языка и культуры. малочисленных народов. Улан-Удэ: Издательство БГУ. 130-132.

Poppe, N. (1965). *Introduction to Altaic Linguistics*. Otto Harrassowitz: Wiesbaden.

Ramstedt, G.J. (1949). *Studies in Korean etymology*. Helsinki.

Рассадин, В.И. (1989). О тунгусо-маньчжурских элементах в монгольских языках. *Этнокультурные процессы в Юго-Восточной Сибири в средние века*. Новосибирск, с.145-152.

Rachewiltz, Igor de. (1972). *Index to The Secret History of the Mongols*. Bloomington.

Rachewiltz, Igor de. (2004). *The Secret History of the Mongols*. Leiden.

Ринчен, Б. (2015). *Монгол бичгийн хэлний зүй*. Дэд дэвтэр. Авиан зүй. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган II боть. Улаанбаатар. Х. 378.

Rozycki, W. (1994). *Mongol Elements in Manchu*. Indiana University: Bloomington.

Санжеев Г.Д., Орловская М.Н., Шевернина З.В. (2015). *Этимологический словарь монгольских языков*. Москва. Том I (А-Е).

Санжеев Г.Д., Орловская М.Н., Шевернина З.В. (2016). *Этимологический словарь монгольских языков*. Москва. Том II (G-P).

Санжеев Г.Д., Орловская М.Н., Шевернина З.В. (2018). *Этимологический словарь монгольских языков*. Москва. Том III (Q-Z).

Санжеев Г.Д., (1930). Маньчжуро-монгольские языковые параллели, *Известия АН СССР*, отделение гуманитарных наук “, Л., сер. VII, № 8, стр. 601-626, № 9. С. 673-708.

Севортян Э.В. (1974). *Этимологический словарь тюркских языков* (Общетюркские и межтюркские основы на гласные). Москва.

Serruys H. (1972). *Šiülengge~šülengge*. Journal of the American Oriental Society. Vol. 92. №1.

Sečenčoytu. (1988). *Mongyol üges-ün ijaγur-un toli*.

Siu Quwa. (2012). Mongyol kelen-ü küriy-e yariyan daki jigelge üge-yin tuqai. *Öbür Mongyol-un Neyigem-ün Šinjilekü Uqayan*. №5. X. 43-49.

Старостин С.А. (1991). *Алтайская проблема и происхождение Японского языка*. М: Наука.

Starostin S.A., Dybo A.V., Mudrak O.A. (2003). *An Etymological Dictionary of Altaic Languages*. Leiden / Boston: Brill. Vol I-III. P. 2096.

Stachowski, M. (2012). Written Mongolian čamča ‘shirt’ and its etymological counterparts in Europe. *Per Urales ad Orientem Iter polyphonicum multilingue, Suomalais-Ugrilainen Seura*. Helsinki. P. 445-451.

Сүхбаатар, О. (1997). *Монгол хэлний харь үгийн толь*. Улаанбаатар.

Төмөрцэрэн, Ж. (2001). *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар.

Төмөртоогоо, Д. (2018). *Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь*. Улаанбаатар. Х. 446.

Tulayuri, Sergei. (2013). Jarud qosiyun-u mongyolčud-un töröl sadun-u öbermiče dayudaly-a ača sinjilekü ni. *Dumdadu ulus-un Mongyol sudulul*. №4. X. 1-11.

Tumurtoogo, D. (2006). *Mongolian Monuments in Uigur-Mongolian Script (XIII-XIV Centuries)*. Introduction, Transcription and Bibliography. Taipei.

Түвшинтөгс, Б. (2009). Историко-сопоставительный анализ глагольной лексики в монгольском и маньчжурском языках. Улан-Батор.

Түвшинтөгс, Б. (2016). Монгол манж хэлний харилцаа холбоог дахин авч үзэх нь. *ОУМЭИХ II хурлын илтгэл*. Улаанбаатар.

Uuda nar. (1985). *Baryu aman ayalyun-u üges*. Öbür Mongyol-un arad-un keblel-ün qoriy-a.

Han-i araha manju gisun-i buleku bidhe. (1717).

Han-i araha sunja hačin-i hergen qamčiha manju gisun-i buleku bidhe. (1794).

Qorin naimatu tayilburi toli. (1994). Namjilm-a emkidkebei. Öbür Mongyol-un arad-un keblel-ün Qoriy-a.

Qorin nigetü tayilburi toli. (1979). Öbür Mongyol-un arad-un keblel-ün Qoriy-a.

Цинциус, В.И. нар. (1975). *Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков*. Материалы к этимологическому словарю, Лгр., Т.I XXIX+1-672.

Цинциус, В.И. нар. (1977). *Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков*. Материалы к этимологическому словарю, Лгр., Т.II, 1-992.

Чимитдоржиева, Г.Н. (2012). *Исторические связи бурятского языка и*

эвенкийского языков (На примере лексики), Улан-Удэ.

Чоймаа, Ш. (2011). *Монголын нууц товчоон*. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, Улаанбаатар.

Чоймаа, Ш. (1990). “Монголын нууц товчооны ‘сэтгэх’ хэмээх үгийн тухай” МНТ-ны 750 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, Улаанбаатар.


Шархүү, Ц. (1973). Манж бичгийн хэлний язгуур үг. МУИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл.

Шиотани, Ш. (2004). *Монгол хэлний үг зүй ба үгсийн сангийн судалгаа*. Улаанбаатар. Х. 290.

Eldendei. (1990). Manju kelen-deki “Mongγol-un Niγuča Tobčīyan”-u üges. *Mongolica. An International Annual of Mongol Studies*, Vol.1(22). X. 189-218.

Eldendei. (1991). Manju kelen-deki “Mongγol-un Niγuča Tobčīyan”-u üges. *Mongolica. An International Annual of Mongol Studies*. Vol.2(23). X. 148-171.

Eldendei, Ardajab. (1986). *Mongγol-un Niγuča Tobčīyan – Seyiregölül tayilburi*. Öbür Mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.